

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ
“УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН” D091701 БАКАЛАВРЫН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

2018 ОН

АГУУЛГА

НЭГ. ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, ҮНДСЭН ҮЕ ШАТУУД	3
1.1. ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН	3
1.2. МАГАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ҮЕ ШАТУУД.....	3
ХОЁР. МАГАДЛАН ШИНЖЛЭЛИЙН ҮР ДҮН.....	5
ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ	5
ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ	9
ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	12
ШАЛГУУР 4. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	20
ШАЛГУУР 5. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	25
ШАЛГУУР 6. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	30
ШАЛГУУР 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ.....	34
ШАЛГУУР 8. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ	39

Товчилсон үгийн товъёог

АНДБЭБ	Ази Номхон Далайн Баруун Эргийн Бүс
АӨСҮТ	Арьсны өвчин судлалын үндэсний төв
АУ	Анагаах Ухаан
АУДҮ	Анагаах ухааны дөрвөн үндэс
АУИС	Анагаах Ухааны Их Сургууль
АУС	Анагаах Ухааны Сургууль
АУТНС	Анагаах ухааны төв номын сан
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БЗХӨ	Бэлгийн замын халдварт өвчин
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНПУ	Бүгд Найрамдах Польш Улс
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ИСНЭ	Их сургуулийн нэгдсэн эмнэлэг
МАУОУС	Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
МУ	Монгол улс
МУА	Монголын уламжлалт анагаах
МУАУ	Монголын уламжлалт анагаах ухаан
МҮБИС	Монголын Улсын Боловсролын Их Сургууль
МҮИС	Монголын үндэсний их сургууль
ОМАУИС	Оточ Манрамба анагаах ухааны их сургууль
ОХУ	Оросын холбооны улс
ӨМӨЗО	Өвөр Монголын Өөртөө Засах Орон
ӨМҮИС	Өвөр Монголын Үндэсний их сургууль
СБЗГ	Сургалтын бодлого зохицуулалтын газар
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ТЗЭШ	Төлөвлөгдсөн зорилготой эмнэл зүйн шалгалт
УА	Уламжлалт анагаах
УАУ	Уламжлалт анагаах ухаан
УАУИ	Уламжлалт анагаах ухааны институт
УАУТХ	Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
УИХ	Улсын их хурал
УНТЭ	Улсын нэгдсэн төв эмнэлэг
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЭМ	Эрүүл мэнд
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
OSCE	Төлөвлөгдсөн зорилготой эмнэл зүйн шалгалт

НЭГ. ШИНЖЭЭЧДИЙН ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, ҮНДСЭН ҮЕ ШАТУУД

1.1. Шинжээчийн багийн бүрэлдэхүүн

БМИҮЗ-ийн ажлын албаны захирлын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 68 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг ажиллав. Үүнд:

- **Цэвээндашийн Дэлгэрсайхан** - МУБИС-ийн Багшийн сургуулийн захирал, боловсрол судлалын ухааны доктор, БМИҮЗ-ийн дэргэдэх Боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийн гишүүн, шинжээчийн багийн ахлагч.
- **Дашлхүндэвийн Самбуудорж** - Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэгийн уламжлалт эмчилгээний тасгийн их эмч, уламжлалт анагаах ухааны тэргүүлэх зэрэгтэй, анагаах ухааны магистр, шинжээчийн багийн гишүүн.
- **Бадарчийн Наранцэцэг** - Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн Эм зүйн сургуулийн захирал, анагаах ухааны доктор, шинжээчийн багийн гишүүн.

1.2. Магадлан шинжилгээний үндсэн үе шатууд

Магадлан шинжилгээ нь үндсэн 3 үе шатаар явагдсан. Үүнд:

- 1). Хөтөлбөрийн тайланг уншиж, шинжээчид урьдчилсан санал дүгнэлтээ гаргасан;
- 2) Тухайн хөтөлбөр хэрэгжүүлж буй сургууль дээр 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 15-ны өдрийг дуустал 2 хоног ажиллав.
- 3). Шинжээчийн баг нь саналаа нэгтгэж, дүгнэлтээ гаргалаа.

1). Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг судалсан байдал:

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг шинжээчийн баг сургуульд ажиллахаас 14 хоногийн өмнө хүлээн авч, уншиж танилцсан. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан нь өмнөх үг, үндсэн 8 шалгуур, дэд шалгуур гэсэн бүтэцтэй, шалгуур бүрд PDCA циклийн дүгнэлт, SWOT шинжилгээ хийгдсэн. Шинжээчийн баг нь тайлангийн бүтэц, бичилтийн агуулга нь магадлан итгэмжлэлийн хөтөлбөрийн шаардлага, үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх, статистик судалгааны дүгнэлт, өгөгдлийн нотлох баримтууд зэргийг нягтлан үзэж, урьдчилсан байдлаар тайланд тодорхойгүй байгаа хэсгүүдийг тодорхойлж, тодруулах асуултуудыг гаргаж бэлтгэсэн.

2). Хөтөлбөр хэрэгжүүлж буй сургууль дээр ажилласан нь:

Шинжээчийн баг нь 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрөөс 15-ны өдрийг дуустал 2 хоног тухайн сургууль дээр ажилласан. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба нь шинжээчийн багийн ажиллах хугацаа болон ажлын хуваарийг тухайн сургалтын байгууллагатай тохиролцож гаргасан. Шинжээчийн баг нь ажиллах хугацаандаа сургуулийн удирдлага, өөрийн үнэлгээний тайлан боловсруулсан багийн ахлагч нар болон багш, оюутан, ажил олгогч, төгсөгчдийн төлөөллүүдтэй уулзалт, ярилцлагыг хийлээ.

Тухайн сургуульд ажиллах хугацаанд тухайн хөтөлбөрийн удирдлагууд, хөтөлбөрийн багш нар анги танхим, интернет, холбогдох техник тоног төхөөрөмжөөр хангах, хөтөлбөрийн оролцогч талуудыг уулзалтад урих, сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаатай холбоотой нотлох баримтуудыг сайн бэлтгэж хамтран ажилласан.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албанаас зохицуулагч Б.Мядагмаа нь хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааг сайн зохион байгуулж, шинжээчийн болон хөтөлбөрийн багууд хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэн, бидний ажлыг хөнгөвчилсөнд багийн зүгээс талархал илэрхийлж байна.

Шинжээчийн баг тухайн хөтөлбөрийн удирлагад тайлангийн үндсэн дүгнэлтийг танилцуулсан.

3). *Шинжээчийн баг саналаа нэгтгэж, дүгнэлтээ гаргасан нь:*

Шинжээчийн баг нь саналаа нэгтгэж, 38 хуудас тайланг хавсралтын хамт бэлтгэж, тухайн хөтөлбөрийн зохицуулагч Б.Мядагмаад хүлээлгэж өгсөн

ХОЁР. МАГАДЛАН ШИНЖЛЭЛИЙН ҮР ДҮН

ШАЛГУУР 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

АШУҮИС-ийн МАУОУС-ийн “Уламжлалт анагаах ухаан” бакалаврын сургалтын хөтөлбөрийг Ази, Номхон далайн бүсийн орнуудын уламжлалт анагаах ухааны стратеги (2014-2024), Номхон далайн баруун эргийн уламжлалт анагаах ухааны бүсийн стратеги (2011-2020) болон МУ-ын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл ба Ази номхон далайн баруун эргийн бүсийн магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс өгсөн зөвлөмж, Монгол улсын эрүүл мэндийн эрдэм шинжилгээг 2008-2015 он хүртэл хөгжүүлэх стратеги, Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, АШУҮИС-ийн хөгжлийн бодлого (2015-2024), “Монгол анагаах ухаан”-ы хөгжлийн бодлого (2015-2025) зэрэг баримт бичгүүдэд тулгуурлан боловсруулсан байна.

АШУҮИС-ийн мэргэжилтний цогц чадамж (2016)-д уламжлалт анагаах ухааны чиглэлээр орчин үеийн анагаах ухааны мэдлэг, ур чадварын тодорхойлолтыг эмнэл зүйн үзүүлэлт, УАУ-ны оношилгоо, үзлэг, гардан үйлдэл, эзэмших ур чадвар, өвчний ангилал, орчин үеийн анагаах ухааны мэдлэг, ур чадварыг эрхтэн системийн эмгэг тус бүрээр тодорхойлон гаргажээ. Уламжлалтын анагаах ухааны их эмчийн хөгжлийн загвар, Уламжлалт анагаах ухааны их эмчийн хөгжлийн зураглал нь тодорхой уялдаа холбоотой байна. Хөтөлбөрийн индексийн хувьд дотоодын ижил төстэй сургууль болох Оточ манрамба анагаах ухааны их сургууль, Шинэ анагаах ухааны их сургууль, МҮИС зэрэг их, дээд сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулахад МАУОУС-д орчин үеийн анагаах ухааны хичээл түлхүү ордог бол бусад сургуульд халдварт өвчин судлал, гэмтэл, эмэгтэйчүүдийн өвчинг уламжлалт анагаах ухаан талаас ордог болохыг харьцуулжээ. Гадаадын ижил төстэй сургуулийн тухайд Ордос АУДЭС, Хөх хотын АУИС, Туньяо АУИС, БНСУ-ын Kyung Kee их сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулахад Хөх хотын АУИС, ӨМҮИС-ийн сургалтын хөтөлбөр нь МАУОУС-тай ойролцоо боловч судалдаг хичээл нь цөөн, орчин үеийн анагаах ухааны агуулга цөөн зэрэг онцлогтой байна. Үүнийг МАУОУС-ийн хамт олон өөрийн

сургалтын хөтөлбөрөө гадаадын бусад оронд туршлага болохуйц, олон улсын чиг хандлага руу ойртсон хэмээн үзэж байна.

Зөвлөмж:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв байдлыг тодорхойлоход анхаарсан байгаа ч сонирхогч талууд гэж хэн болох тэдэнд ямар эрэлт хэрэгцээ байгаа зэрэгт тогтож дүн шинжилгээ хийх тал дээр цаашид анхаарах.
- Хөтөлбөрийн индексийн хувьд дотоодын ижил төстэй их, дээд сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулан дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ, ялангуяа гадаадын улс орнуудад энэ чиглэлээр ямар бодлого, чиг хандлага, хувь хүний болон нийгмийн ямар эрэлт хэрэгцээ байгааг судалж, төгсөгчдийг дотоодод төдийгүй гадаадад ажиллуулах боломж, гарц, арга замыг эрэлхийлэх нь зүйтэй.
- Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй өнөөгийн тогтолцоог салбарын харьяалах яам, газрууд анхааралдаа авч, энэ чиглэлд хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ энэ чиглэлийн нарийн мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх асуудалд төрийн зүгээс урт хугацааны бодлого зайлшгүй шаардлагатай байна.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой, төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Салбарын бодлоготой уялдуулан, “Монгол анагаах ухаан, орчин үеийн анагаах ухааны нотолгоонд суурилсан, нэгдмэл сургалтын хөтөлбөр (integrated curriculum) гэсэн үзэл баримтлалын дагуу сургалтын хөтөлбөрөө боловсруулан, зах зээлийн эрэлтэд нийцсэн мэдлэгтэй боловсон хүчин бэлтгэхэд анхаарчээ. Хөтөлбөрийн зорилго нь “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс Судлал”-ын болон орчин үеийн анагаах ухааны нэгдмэл сургалтын хөтөлбөрөөр чадамжид суурилсан бакалаврын боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн байна. Оюутан суралцагчид 1, 2-р дамжаандаа ерөнхий эрдэм, анагаах ухааны суурь боловсролыг, 3-р дамжаанд Монгол анагаах ухааны суурь боловсрол, 4, 5-р дамжаанд Монгол анагаах ухаан болон орчин үеийн анагаах ухааны эмнэлзүйн сургалтын нэгдмэл хөтөлбөрөөр суралцан, төгсөх анги буюу 6-р дамжаанд Монгол анагаах ухааны дадлагажих эмнэлзүйн сургалтыг дүүргэдэг байна.

Уг хөтөлбөрийн онцлог давуу тал нь өвчнийг уламжлалт анагаах ухааны үндсэн суурь зарчимтай уялдуулан оношлох, эмчлэх, үр дүнг дүрслэл оношилгооны өндөр мэдрэг багажаар нотлох чадварыг суралцагч эзэмшихэд чиглэсэн явдал юм.

Сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний системийн тухайд “Эмнэлзүйн дадлага-II” удирдамжид оюутныг үнэлэх арга аргачлалыг тусгасан байна. Сургалтад асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргыг Язгуурын үндэс, Эмийн жор судлал, Зүү төөнө, Дотрын өвчин судлал зэрэг зарим хичээлд хэрэгжүүлдэг бөгөөд эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг эрэмбэлэх, дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулах, түүний явцыг хянах, үр дүнг үнэлэх зэрэг шинжлэн судлах аргаар сургалтыг зохион байгуулдаг нь сайшаалтай.

Багш оюутны мэдлэгийн түвшинг үнэлэх, суралцах идэвхийг дэмжих, эрчимжүүлэх, тэдэнд өөрөө өөртөө дүгнэлт хийх боломжийг олгох, төлөвлөх зорилгоор явцын болон эцсийн үнэлгээ хийдэг нь оюутны суралцах, хөгжихөд эерэг нөлөөтэй байна. Төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлохдоо хувь хүний төлөвшил, хүний их эмчийн мэргэжил, сургалтын хүрээнд эзэмших үр дүнгээр тодорхойлон, сургуулийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэх 6 цогц зорилтыг дэвшүүлжээ. Уламжлалт анагаах ухааны сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилгоор ажил олгогч нар болон уламжлалтын эмч нарын төлөөлөл, багш нар, төгсөгчид оролцсон хэлэлцүүлэг, уулзалт, хурлыг 2014 онд эрчимтэй зохион байгуулжээ.

Зөвлөмж:

- Төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагыг уламжлалт анагаах ухааны болон орчин үеийн анагаах ухааны чиглэлээр тодорхойлсон байдалдаа дүн шинжилгээ хийж, эдгээрийн зохистой харьцаа (баланс) нь ямар байвал өнөөгийн нийгэмд нийцтэй болох талаар нарийвчилсан судалгааг цаашид үе шаттайгаар тогтмол хийдэг байх нь зүйтэй юм.
- Төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг хичээл судлагдахууны нэршлээр ерөнхийлөн авах бус харин тухайн хичээл судлагдахуунаар олгож буй тодорхой мэдлэг, ур чадвар, хандлагаар нь нарийвчилсан судалгааг авдаг байх нь уг сургалтын хөтөлбөрийн цаашдын хөгжилд сайнаар нөлөөлнө гэдгийг анхаарч ажиллах хэрэгтэй.

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
- Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Уламжлалт анагаах ухаан 3 жилийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг 1990-1993 онд, 6 жилийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг 1991 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд түүнээс хойш уг төлөвлөгөө, хөтөлбөр нь 1995, 1998, 2005, 2008, 2015 онуудад тус тус шинэчлэгджээ.

2015 онд сургалтын төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахдаа БСШУ-ы Сайдын 2014 оны А/174 тоот тушаалын хавсралт “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг баримтлан боловсруулж, АШУҮИС-ийн захирлын 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулсан байна. Сургалтын төлөвлөгөө нь бүтцийн хувьд ерөнхий суурь-27,8%, мэргэжлийн суурь-23,7%, мэргэжлийн-48,5% байгаа нь дээр дурдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг хангасан хэмээн үзэж болно.

АШУҮИС-ийн бакалаврын түвшний суралцагчид мэргэжлийн бүх салбарын оюутны үйлдвэрлэлийн, эмнэлзүйн, технологийн, танилцах болон эрдэм шинжилгээний туслах ажилтны дадлагыг сургалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу өрх, сумын эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, улсын төв эмнэлэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн төв, хувийн эмнэлгүүдэд хийдэг нь онол, практикийг зохистой хослуулан хэрэгжүүлэх нөхцөл болсон байна.

- Өмнөх сургалтын төлөвлөгөө (2010)-н дэх Орчин үеийн анагаах ухааны “Дотор өвчин судлал” хичээлийг дотор нь задалж Зүрх судас судлал (4 кр), Уушги судлал (4 кр), Хоол боловсруулах эрхтэн судлал (4 кр), Бөөр судлал (2 кр) чиглэлээр нарийсгаж, уламжлалт анагаах ухаантай уялдаатай оруулах болжээ. Мөн сургалтын төлөвлөгөөний “Мэргэшүүлэх хичээлүүд” багцад Өрхийн анагаах ухаан (4 кр), Чих, хамар, хоолой судлал (1 кр), Эрэгтэйчүүдийн өвчин (2кр) зэрэг хичээлийг нэмж оруулсан нь суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн, төгсөгчдийн болон ажил олгогчдын эрэлт хэрэгцээ, саналыг харгалзан тусгадгийн илрэл нотолгоо болж байна.

Зөвлөмж:

Оролцогч, сонирхогч талуудаас авах санал, зөвлөмж, асуумжийг төрөлжүүлэн нарийсгаж, тодорхой болгон боловсруулж, судалгаа авдаг байх хэрэгтэй. Судалгааны асуумжийг хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээ болон суралцагчийн эзэмших хувийн болон мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшлөөр нарийвчлан боловсруулах нь хөтөлбөрийн шинэчлэлийн үр өгөөж болон цаашид анхаарч засаж залруулах асуудлыг илрүүлэх гол хөшүүрэг болно. Судалгааны асуулгыг он, сараар баталгаажуулах, сонирхогч талуудын санал зөвлөмжийн үнэлгээ, дүгнэлтийг схем, диаграмм, хүснэгтээр тодорхой зураглан харуулдаг байх нь зүйтэй.

ШАЛГУУР 2. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, ТЕХНОЛОГИЙН НӨХЦӨЛ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал

- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

АШУУИС-ийн МАУОУС нь өмнөх магадлан итгэмжлэлийн дүгнэлтээр 1 оюутанд ноогдох сургалтын орчны хэмжээ 2.5 м² байсан ба сургалтын бааз барилгуудыг шинээр ашиглалтанд оруулснаар 3.5 м² болж нэмэгдсэн нь дээд боловсролын байгууллагад тавигдаж буй стандарт шаардлагын хэм хэмжээг хангаж байна.

Тус сургууль нь багш оюутны сургалт, судалгаа явуулах, өөрийгөө хөгжүүлэх, хэрэгцээтэй мэдээ мэдээллээр хангагдах, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, эрүүл, аюулгүй орчныг улсын төсвийн болон сургуулийн хөрөнгө оруулалт, БНХАУ, Япон улсын хамтын ажиллагааны хүрээнд хангалттай хэмжээнд бүрдүүлсэн байна. Ялангуяа, багш оюутны эрүүл мэндийг дэмжих, оюутнуудад эмнэлзүйн ур чадвар олгох, бие даан суралцах нөхцөл бололцоог хангах зорилгоор техник технологийн дэвшил, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн дотоод нөөц бололцоогоо ашиглан, сургуулийн орчныг шинэчлэн зохион байгуулах талаар тодорхой бүтээлч ажлуудыг хийж хэрэгжүүлжээ. Үүнд:

- Ногоон байгууламж, усан оргилуур бүхий эрүүл, тохилог орчин, оюутны бие даан болон багаар ажиллах мөн бусад хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээтэй “Эко цогцолбор”-г 2015 онд ашиглалтанд оруулсан
- 7 давхар оюутны номын сан, цөм лабораторийг ашиглалтад оруулж, зайн сургалтын төв болон онлайн хэлбэрээр хичээл судлах, нэгдсэн шалгалт авах тогтолцоог бүрдүүлсэн.
- Хичээл сургалт явуулдаг анги танхимыг засаж, тохижуулан, LCD, проектор, “Смарт индэр”-ээр тоноглож, интернет орчинд чөлөөтэй нэвтрэн, хэрэгцээтэй мэдээллийг авах орчин нөхцөлөөр хангасан байна.
- Уламжлалт анагаахын нандин өв санг хадгалах, сурталчлан таниулах зорилгоор “Уламжлалт анагаах ухааны музей”-г байгуулж, сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.
- Багш оюутны эрүүл мэндийг дэмжих зорилгоор биеийн тамирын заалыг олон улсын стандартад нийцсэн шалтай болгон тохижуулж, фитнес төвийг нээн, уг төвд оюутнуудад зориулсан иогийн сургалтыг тогтмол явуулдаг байна.
- Сургуулийн орчинд үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээний цэгүүдэд эрүүл ахуйн шаардлага хангахгүй бүтээгдэхүүн зарж борлуулахыг нэр зааж, хориглосон нь оюутны эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох нөхцөлийг хангахад чиглэсэн ажил болжээ.
- Хичээлийн байрыг камержуулж, оюутны хувийн эд зүйлээ хадгалах шкаф, шүүгээтэй болсон нь аюулгүй, тав тухтай орчинг бүрдүүлэхэд чухал алхам болсон байна.
- Оюутнуудад эмнэлзүйн ур чадвар олгох, бие даан суралцах нөхцөл бололцоог хангах зорилгоор “Уламжлалт анагаахын засалч ангийн ур чадварын төв”, “Зүү төөнө заслын их эмч” ангийн ур чадварын төвийг 2016 онд ашиглалтанд оруулсан.
- МАУОУС нь 20 ор бүхий сургалтын бааз эмнэлгийн эрхийг 2016 онд авч, оюутанд эмнэлзүйн ур чадвар олгох, тэдний дадлага хийх орчныг бүрдүүлсэн.
- 2009 оноос улирлын чанартай “Эрхэс” сувиллын үйл ажиллагааг эхлүүлснээр оюутны дадлагын баазтай болсон байна.

- Дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах нийтлэг шаардлага"-ын хүрээнд 2.5.4-т заасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, багш, оюутныг нэвтрүүлэх зориулалтын шат, ариун цэврийн өрөөтэй байна” гэсэн заалтын дагуу орчныг тодорхой хэмжээнд тохижуулсан байна.
- 2016 онд шинээр 49 компьютер бүхий лабораторийг 100 сая төгрөгөөр шинээр тохижуулан зохион байгуулжээ.
- Хичээлийн төв байр болон “Эко цогцолбор”-н 2 давхар, сургуулийн номын санд оюутнуудын багаар ажиллахад шаардлагатай хэрэгсэл, орчныг бүрдүүлсэн байна.
- Интерактив хичээлийн өрөө нь өмнөх магадлан итгэмжлэлийн үед 3 байсныг 13 болгон нэмэгдүүлжээ.

Зөвлөмж:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан сургуулийн орчныг сайжруулах талаар цаашид анхааран ажиллах

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Тус сургууль нь багш оюутныг сургах, сурах үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамж, хичээлийн хэрэгсэл, ном, гарын авлагаар бүрэн хангасан байна. Ялангуяа уламжлалт анагаах ухааны үндсэн тулгуур сурах бичиг болох Анагаах Ухааны Дөрвөн Үндсийг монгол, англи, төвд хэлээр хадмал орчуулгатай Мүүдл программд оруулж, интернет орчинд хаанаас ч сургалт судалгаанд чөлөөтэй хэрэглэх боломжийг бүрдүүлжээ.

Мөн 2016 онд шинээр зохион байгуулсан зүү төөнө заслын ур чадварын төвд компьютерийн программ хангамжид суурилсан 2 төрлийн судасны лугшилтын бичлэгийн аппарат, хэл оношилгооны төхөөрөмж, “42 инч бүхий хүний биеийн зүүний сүвийн байршил зүйн интерактив мультимедиа дижитал платформ”, “19 инч бүхий хүний биеийн зүүний сүвийн байршил зүйн интерактив мультимедиа дижитал платформ”, уламжлалт анагаахын 16 төрлийн судасны лугшилтыг тэмтрэхэд зориулсан гарны муляж 8 ширхэг, зүү хатгалтын симулятор зэргийг байршуулж, сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа нь оюутны ур чадварыг сайжруулах, бие даан суралцах нөхцөл боломжоор хангаж байгаа нь харагдаж байна.

Түүнчлэн Японы Токио Ариаке Их Сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд 24 төрлийн 80 ширхэг сурах бичиг, 4 төрлийн эмчилгээний аппарат, 6 төрлийн нурууны хамгаалалт, 13 төрлийн үе хамгаалалт, 5 төрлийн үений үйлдэл хөдөлгөөний модель гэх мэт нийт 287 ширхэг багаж материалыг хүлээн авч, сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Орос, Хятад, Өвөрмонголоос болон багш нарын нөөц бололцоонд

тулгуурлан, уламжлалт анагаах ухааны заслын VCD-г бариа, төөнүүр, соруул засал, иогийн хичээлээр бэлтгэн, сургалтанд хэрэглэж байгаа зэрэг оюутанд чиглэсэн, тэдний амжилттай сурах нөхцөлийг бүрдүүлсэн, олон талт ажлыг хийсэн ахиц дэвшилтэй байгаа нь өмнөх магадлан итгэмжлэлийн “сургалт явуулах анги танхим, лабораториудыг орчин үеийн эмнэлзүйн нарийн багаж, тоног төхөөрөмжөөр хангах” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлсэн гэж үзэх үндэстэй байна.

МАУОУС нь АШУУИС-ийн төгсөлтийн, төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааны холбогдох заавар журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг ба АШУУИС нь “Сургалтын бодлого зохицуулалттай холбоотой дүрэм, журмын эмхтгэл” номыг жил бүр хэвлүүлж, бүх багшид хүргэдэг байна. Энэхүү эмхтгэлийг мөн онлайн хэлбэрээр харах боломжтой нь онцлог байна.

Зөвлөмж:

Симуляци виртуаль лабораторийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ
- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

АШУУИС-ийн номын сан /Анагаах Ухааны Төв Номын Сан/ нь 2015 онд 848 м² талбай бүхий зориулалтын барилга байгууламжтай болсноор суудлын тоо 336-аар нэмэгдэж, хүртээмж сайжирсан нь өмнөх магадлан итгэмжлэлийн “номын сангийн уншигчийн суудлын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах” зөвлөмжийг хэрэгжүүлсэн ажил болжээ. Түүнчлэн тус номын сан нь фонд бүрдүүлэлтийг жил бүр төлөвлөгөөтэй хийж ирсэн ба нийтдээ 157792 боть номтой бөгөөд уламжлалт анагаах ухааны ном сурах бичиг үндсэн фондын 10%-г эзэлж байгаа нь МАУОУС-ийн оюутанд хүрэлцэх хэмжээнд байна.

Дээд боловсролын байгууллагын хөгжлийг дэмжих төслийн хүрээнд Азийн хөгжлийн банк, БСШУЯамны санхүүжилтээр “Ном нөхөн сэлбэх, сэргээн засварлах” 71200000 төгрөгийн төслийг амжилттай хэрэгжүүлснээр 36 м² бүхий ном сэлбэн засах өрөөнд урсгал засвар хийн тохижуулж, ном сэргээн засварлахад шаардлагатай 22 нэр төрлийн тоног төхөөрөмж /ном ариутгагч аппарат, гуурсан үдэгч, зүсэгч, горивдогч машин, нуруулдах, хавтаслах, ном сканердах төхөөрөмж гэх мэт/, техник хэрэгслээр хангаж, ном сэлбэн засагчийн орон тоог шинээр бий болгосон ба төслийн хугацаанд 1040 ширхэг номын 6280 хуудсыг сэргээн засварлаж, номын сангийн сан хөмрөгийн 5.3%-г ариутган цэвэрлэсэн байна. Ялангуяа эмнэлзүйн хичээлийн эмнэлгийн орчинд хэрэглэгддэг ном сурах бичгийг нэн тэргүүнд ариутган цэвэрлэхэд анхааран ажилладаг нь багш оюутны эрүүл мэндийг дэмжсэн, халдвар хамгааллын нөхцөлийг бүрдүүлсэн чухал алхам болсон байна.

Мөн цахим номын сангийн фондтой болсон ба энэ нь монгол, гадаад хэл дээрх цахим ном, сэтгүүл, лекц, эрдэм шинжилгээний бүтээл, мультимедиа, интерактив хичээлүүдээс бүрдсэн ба АШУҮИС-иас эрхлэн гаргадаг 3 сэтгүүлийг 2012 оноос эхлэн цахим хэлбэрт оруулж, нийт 38 дугаарын 192 өгүүллийг цахим хувилбараар цуглуулж, 2014 оноос цахим лекцийг бүрдүүлж, нийтдээ 226 цахим лекцтэй болсон байна.

Сургалт судалгааны Hinari, Pubmed, Medline зэрэг анагаах, биоанагаахын мэдээллийн чухал эх сурвалжаас 8000 гаруй сэтгүүл, 20 сая гаруй өгүүлэл бүхий мэдээллийн санг нээлттэй ашиглах боломжтой болсон нь багш оюутны сургалт, судалгааны хэрэгцээ шаардлагыг хангахад бодит хувь нэмрийг оруулсан байна.

Тус сургуулийн номын сан нь Монголын номын сангийн консорциум, Их дээд сургуулиудын номын сангийн холбооноос 2016 оны онцлох “Шилдэг төсөл-Эко үйлчилгээ” нэвтрүүлсэн номын сангаар шалгарсан явдал нь номын сан, мэдээллийн эх үүсвэрийг сайжруулах талаар хийсэн бодит ажлын тодорхой үр дүнг харуулсан илрэл нотолгоо болж байна.

Зөвлөмж:

Цаашид сургалт судалгаанд шаардлагатай лицензтэй программуудын тоог нэмэгдүүлэх талаар анхаарал хандуулан ажиллах

ШАЛГУУР 3. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцсэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлсэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлж байна. Үүнд: хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэдээллийн тогтолцоо буюу их сургуулийн удирдлага, мэдээллийн

UNIMIS системийг нэвтрүүлснээр сургалтын бодлого зохицуулалтын газар, багш, суралцагчид, тэдний эцэг, эх хоорондын харилцаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглах боломж, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, сургалтын мэдээллийн нэгдсэн санг бий болгох зорилгыг ханган ажиллаж байна.

АШУҮИС-ийн захирлын 2015 оны 10-р сарын 09-ний өдрийн А/113 тоот тушаалаар багшийн хөгжлийн болон хөтөлбөрийн зөвлөл байгуулагдан ажилласан байна. Хөтөлбөрийн сургалтын арга зүйг оюутан төвтэй буюу суралцагч төвтэй болгож бие даан суралцах бололцоог хангаж, хичээлийг PBL, эмнэлзүйн тохиолдолд суурилсан дадлага жижиг бүлгийн сургалтаар явуулдаг болсон нь оюутны бие даах чадварыг нэмэгдүүлэхэд дөхөм болжээ.

Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журамд БСШУЯ сайдын 2014 оны 4-р сарын 28 өдрийн А/174 тоот тушаалд заагдсан бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу нийт багц цагийн 30% суурь, 25% мэргэжлийн суурь, 45% мэргэжлийн хичээл байхаар бүрдүүлж, тухайн хичээл тус бүрийн 25% бататгах цагийг багтаасан байна. АШУҮИС-ийн захирлын 2015 оны 12 сарын 15-ны өдрийн А/144 тоот тушаалын III хавсралтаар баталсан “АШУҮИС-н сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам”-ын 3 бүлэгт заасны дагуу хичээлийг явуулж байна.

2016 оноос эхлэн 3,4-р дамжааны оюутнууд зүүний сүвийн байршил зүй, зүү эмчилгээ, онош зүй зэрэг хичээлүүдийн дадлагыг сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох эмнэлзүйн дуураймал орчинд гардан үйлдлийн ур чадвараа сайжруулах төв байгуулан ажиллаж байна.

Урт хугацааны төлөвлөгөөнд АШУҮИС-ийг 2014-2020 онд хөгжүүлэх төлөвлөгөө, МУ-ын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл ба Ази номхон далайн баруун эргийн бүсийн магадлан итгэмжлэлийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүд, МУ-ын Дээд боловсролын УАУ сургалтын хөтөлбөр MNS 5323-128-2012 стандарт, ЭМ-ийн сайдын 2012 оны 102 тоот тушаал “УАУ сургалтын хөтөлбөрөөр бакалавр зэрэгтэй төгсөгчдөд тавигдах шаардлага, Өрхийн ЭМ-ийн төвийн үйл ажиллагааны гарын авлага, МАУ-ы хөгжлийн бодлого (2015-2025), Монгол улсын засгийн газрын мөрийн хөтөлбөр (2016-2020) зэрэг бодлогын баримт бичигт тулгуурлан “Уламжлалт анагаах ухаан сургалтын хөтөлбөрийн их эмчийн эзэмших цогц чадамж” (2016), “Уламжлалт анагаах ухаан бакалаврын сургалтын хөтөлбөр” (2017) зэргийг боловсруулсан нь Монгол анагаах ухааныг хөгжүүлэх үзэл баримтлал, судалгаа, сургалт, мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичиг болсон байна.

Богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизмыг он, оноор гаргасан байгаа нь ажлын үнэлгээ, гүйцэтгэл болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилтийг үнэлэхэд ахиц дэвшил болж чадсан байна.

Зөвлөмж:

Шинэчилсэн хөтөлбөрийн агуулгын хүрээнд сурах бичгийг шинээр бичиж, хөтөлбөрийн зөвлөлөөр хэлэлцүүлж, хэвлэхэд анхаарах

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Хөдөлмөрийн зах зээлд УАУ-ны эмч, сувилагч, сэргээн засахын эмч, сувилагч нарын эрэлт хэрэгцээ их байгаа тул эдгээр чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж, хэлэлцүүлэх шаардлагатай байгааг бодлогын баримт бичгүүдэд тулгуурлан онцолсон байна.

МАУОУС нь хөтөлбөрийг сурталчлах хүрээнд хөтөлбөрийн талаар гадаад, дотоодын олон сургалт, оюутан суралцагчдад хөтөлбөрийг сурталчлан идэвхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд өдөрлөг, тэмцээн уралдаан, ЭШ-ний чуулган зохион байгуулдаг байна. Үүнд: МАУОУС нь хөтөлбөрийг сурталчлах хүрээнд богино хэмжээний кино хийсэн, Хятад-Монгол анагаах ухааны экспод 2 удаа оролцсон, МАУОУС-д уламжлалт анагаах ухааны засалчийн анги шинээр нээсэн бөгөөд Токио Ариаке Их Сургуулийн багш нар тус сургуульд ирж хичээл зааж үнэ төлбөргүй үзлэг сургалт зохион байгуулсан байна. Уламжлалт анагаах ухааны сургуулийн багш нар БНСУ-ын Пусан хотын эмч нартай хамтран зүү төөнө заслын сургалтыг 2011 онд, БНПУ-д Уламжлалт анагаах ухааны чиглэлээр ажиллаж байгаа эмч нарын дунд сургалт зохион байгуулж, мэргэжлээ сурталчилсан байна. Мөн оюутан суралцагчдад чиглэсэн мэдээлэл солилцох өдөрлөг, спортлог оюутан өдөрлөг, МАУОУС-ийн спортын бага наадам, ӨМӨЗО-ны оюутны төлөөлөл Улаанбаатар хоттой танилцах өдөрлөг, Cardiology club-тай хамтарсан зүрхний сургалт, IMSAC 2017 ОУ-ын анагаахын оюутнуудын эрдэм шинжилгээний анхдугаар чуулган гэх мэт олон үйл ажиллагааг зохион явуулжээ.

Багш нарын ЭШ-ний бүтээлийг зах зээлийн эргэлтэнд оруулахад АШУҮИС, МАУОУС, ЭМСЯ, ШУТС, Улсын болон хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд тус сургуулийн багш нарын бүтээлүүдийг зах зээлд борлуулах талаар ЭМ-ийн сайдын тушаал гарсан байна.

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандалт судалгааг УАУ-ны чиглэлийн төрийн болон хувийн өмчийн их, дээд сургууль төгсөгчдийн тайлан мэдээнд тулгуурлан нарийвчлан гаргаж, дүн шинжилгээг хийх
- МАУОУС-ийн төгсөгчдийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусалдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ

-
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
 - Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

МАУОУС-ийг 1993-2016 онд 816 уламжлалт анагаах ухааны эмч төгсөж, 82.5% нь ажил эрхэлж байна. Гадаад, дотоодын их дээд сургуулиудад магистрант, докторант, резиденсийн чиглэлээр үргэлжлүүлэн суралцаж байгаа төгсөгчид 143 буюу 61.5%-ийг эзэлж байгаа бөгөөд үргэлжлүүлэн суралцагчдын 41 нь АУ-ы доктор, 73 нь АУ-ы магистр хамгаалсан ба 91 нь зүүний резиденсийн сургалтыг дүүргэсэн байна. Сүүлийн 5 жилд Зүү төөнө заслын чиглэлээр 68, УАУ-ны чиглэлээр 23, бариа заслын чиглэлээр 100 гаруй мэргэжилтэн сургалтанд хамрагдсан нь ахиц дэвшил болжээ. Нийт төгсөгчийн 78.1% нь гадаад, дотоодын уламжлалт анагаах ухааны салбарт хүч хөдөлмөрөө зориулан ажилладаг тоо баримт байна.

Төгсөгчдийн 5,5% нь анагаах ухааны чиглэлийн их, дээд сургууль, ЭШ-ий хүрээлэнгүүдэд ажиллаж шинэ эм бэлдмэл гарган авах, эмчилгээний арга нэвтрүүлэх, эмч, судлаач мэргэжилтэнгүүдийг бэлтгэх сургалтын тасралтгүй үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байгаа юм байна.

МАУОУС төгсөгчдийн сургалтаар магистрын сургалтыг онлайнгаар явуулж мэргэжлээрээ судалгаа хийх боломж олгож сургалтын таатай орчинг бүрдүүлэн сургалтын чанарыг дээшлүүлж, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэн суралцагчдыг дэмжих бодлогыг барьж ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

МАУОУС нь 2017 оноос эхлэн 14 хоногт 1 удаа “Төгсөгчдөө алдаршуулъя аян” зохион байгуулж, 1993 оноос хойш УАУ-ны салбарт тэргүүлэн ажиллаж байгаа он оны төгсөгчдийн уулзалтыг зохион байгуулдаг байна.

Зөвлөмж:

Ажил олгогчид, төгсөгч нартай хийсэн уулзалтаас харахад сургалтын хөтөлбөрийн агуулгын шинэчлэлд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Оюутан суралцагчдад сонгосон мэргэжлийнхээ үнэ цэнэ, мэргэжилдээ дур сонирхолтой байх, мэргэжлээрээ бахархах, цаашид өсөн дэвжих хүсэл тэмүүллийг өдөөх ажлуудыг хэрэгжүүлэх.
- Хөдөө орон нутгийн төгсөгчдөд зайн сургалтуудыг хүргэх талаар санаачилгатай ажиллах
- Цаашид төгсөлтийн дараах сургалтын чиглэлүүдийг тодорхой болгох, УАУ-ны эмч нарыг хөрвөх чадвартай бэлтгэх талаар анхаарлаа хандуулж ажиллах шаардлагатай байна.

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож, багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

-
- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
 - Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
 - Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Олон улсын хамтын ажиллагааны хувьд гадаадын зарим их, дээд сургууль, судалгааны болон мэргэжлийн байгууллагатай холбоо тогтоож багш, суралцагч солилцох, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтарч ажилладаг байна.

Гадаад хамтын ажиллагаанаас дурдвал:

1. Жудо бариа заслыг дэлгэрүүлэх тухай-АШУҮИС болон Японы жудо бариа засалчдын холбооны хамтын ажиллагааны санамж бичиг 2014.II.11, Korea institute 2015.03.03, Тяньжины их сургууль 2014.10.10, Ордос дээд сургууль 2013.04.24, БНХАУ-ын Өвөр монголын үндэсний их сургууль 2014.01.08, Тунляогийн Үндэсний их сургуультай сургалт, эрдэм шинжилгээ, эмнэлзүйн чиглэлээр олон гэрээ, хэлэлцээр, ажлын үр дүн, үйлдвэрлэлд нэвтэрсэн шинэ ажлууд хийгдсэн байна. Эдгээр гэрээ хэлэлцээрийн үр дүнд Монгол анагаах ухааны клиникийн эмнэлэг байгуулах, эмнэлзүйн судалгааны лаборатори байгуулах, доктор магистр сургах, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч мэргэжилтэн бэлдэх, багш, оюутны солилцоо зэргээр хөтөлбөрийн хэрэгжилт биелэгдэж байгаа нь харагдаж байна.

2. “Жоншноос эмийн уламжлалт технологийн аргаар биологийн идэвхит бэлдмэл гарган авах” инновацийн төсөл /2011-2014/ Биологийн идэвхит бүтээгдэхүүний бүртгэлийн гэрчилгээ 2, Остеокальци-5, Антацид кальци-6 хэмээх 2 эмийг шинээр гарган авчээ.

3. “Хүнсний гаралтай хордлого тайлах ногоон буурцгийн шинэ бэлдмэл гарган авах” 2012-2014 суурь судалгааны сэдэвт төсөлт ажил хийгдээд тайлан бичигдсэн байна.

Мөн МАУОУС-д Жудо бариа засалчийн анги шинээр нээгдсэн бөгөөд Токио Ариаке Их сургуулийн багш нар тус сургуульд ирж хичээл заадаг байна.

Түүнчлэн ӨМӨЗО-ы Тунляогийн Үндэсний Их Сургуулийн Хараат эмнэлгийн хороонд 15 оюутан дадлага, Хөх хотын анагаахын сургуулийн 4 багш, 6 оюутан Монгол улсад эмийн ургамлын дадлага, 2015 оны 10 сард МАУИ-ийн оюутнууд ӨМӨЗО-ы ОУ-н Монгол эмнэлгийн хороонд эмнэлзүйн хичээлийн дадлага хийж, 2016 оны 09 сард Тяньжиний АУИС-д 10 оюутан зүү төөнө заслын чиглэлээр 4+2 хөтөлбөрийн хүрээнд суралцсан зэрэг нь багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилт сайн байгааг харуулж байна.

Зөвлөмж:

- Хөдөө орон нутагт ажиллаж амьдарч байгаа төгсөгчдийг гадаадын их, дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинарт оролцуулах тал дээр анхаарах
- Цаашид оюутан солилцооны хамрах хүрээг нэмэгдүүлж, хамтарсан төсөл хөтөлбөрийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд анхаарч ажиллах

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

МАУОУС нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ - уудтай хамтран ажилладаг байна. Дотоод хамтын ажиллагаанд НЭМГ, УНТЭ, УХТЭ, ШУГТЭ, ГССҮТ, ХСҮТ, СЭМҮТ, ЭХЭМҮТ, АӨСҮТ, ЦССҮТ, ТТАХНЭ, УАУТХ, ЭСҮТ, УБТЗТЭ, ШШҮХ зэрэг 16 эмнэлэгтэй гэрээ байгуулсан байна. МАУОУС-ийн “Клиник эмнэлэг” – т 2016 оноос хойш 870 гаруй үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж, 1300 үйлчлүүлэгч амбулаториор үйлчлүүлсэн ба тус эмнэлэг нь уламжлалт анагаахын чиглэлээр 20 гаруй төрлийн тусламж үйлчилгээг үзүүлдэг байна.

2009 онд МАУОУС-ийн “Эрхэс” сувилал үйл ажиллагаагаа эхлүүлж, сүүлийн 5 жилд 1538 хүнд эрүүл мэндийн тусламж үзүүлжээ.

Дотооддоо ЭШ-ний хамтарсан хурал 5 удаа зохион байгуулсан байна. Багш, суралцагчдын зүгээс нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүнг тооцож үзэхэд олон бүтээлч ажил зохион байгуулсан нь харагдаж байна. Үүнд: МАУОУС-н багш нар жилд нэг удаа ХУД – ийн 12 – р хорооны ард иргэдэд болон СБ дүүргийн “Шижиддүг” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран 300 гаруй ард иргэдэд үнэгүй үзлэг оношилгоо хийж хэвшсэн байна. Мөн Японы Ариаке их сургуулийн жудо бариа заслын эмч нарын багтай 2016, 2017 онуудад хамтран ажиллаж, УБ хотын иргэдэд спортын гэмтэл бэртлээс үүссэн өвчний чиглэлээр үзлэг хийж нийт 300 хүнийг хамруулсан зэрэг олон ажлыг амжилттай зохион байгуулжээ.

Зөвлөмж: Цаашид дотоодын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай тодорхой чиглэлүүдээр хамтран ажиллах тал дээр анхаарах

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Дүгнэлт:

МАУОУИС-ийн төсөв нь жил ирэх бүр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ нь оюутны тоо болон сургалтын төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна. 2017 оны төсвийг 2011 оныхтой харьцуулбал, 2.5 дахин өссөн үзүүлэлттэй байна.

МАУОУИС-ийн 2011, 2014, 2017 оны төсөв

Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн төсөв		
2011 он	2014 он	2017 он
207222300	214056900	534542900

2015 оны сургалтын төлбөрийн задаргааг авч үзвэл сургалтын төлбөрийн 68,44 хувь нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд, 13,44 хувь нь хичээл практик, ном хэвлэлийн зардал, нормын хувцас зэрэгт зарцуулагдсан байна.

Үндсэн бус үйл ажиллагааны орлого нь /2013 онд 28 сая, 2014 онд 34 сая, 2015 онд 28 сая/ сургуулийн эмнэлэг, сувиллын газраас, төсөл хөтөлбөрөөс олсон ашиг 2013 онд 31 сая төг цугларсан байна. 2017 оны батлагдсан төсөв нь 534542900 сая төгрөг байна. Үүнээс:431748,600 сая төг буюу 81%-ийг цалин хөлс болон нэмэгдэл урамшилд төсөвлөсөн байна.

2017 оны төсөвт эрдэм шинжилгээний ажил болон сургалт семинарын зардал огт тусгагдаагүй байгаа нь анхаарал татсан асуудал байна. Гэтэл АШУУИС-ийн 2018 оны орлого, зардлын төсвийн нэгдсэн товчоо (Удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 006 тоот тогтоолын I хавсралт)-нд ЭШ-ний ажлын зардалд 1,101,725.0 төгрөг төсөвлөсөн байна.

БНХАУ-ын Тунляогийн их сургуулиас Их сургуулийн нэгдсэн эмнэлгийн уламжлалт анагаах ухааны клиникийн байрны түрээсийн бүтэн жилийн хугацаанд нийт 48600000 төгрөгийн дэмжлэг, мөн 563251169 төгрөгийн 71 ширхэг тоног төхөөрөмж /смарт эмчийн аппарат 1ш, ком дунд давтамжит эмчийн аппарат 4 ш, цахилгаан зүү, ком термостат, лаа аппарат 1 ш, АВС эмнэлгийн зориулалтын ор 25 ш, зэвэрдэггүй орны шүүгээ 25 ш, хэт авиан төхөөрөмж 1ш гэх мэт/-ийг эмнэлэгт буцалтгүй тусламжаар бэлэглэжээ.

Зөвлөмж:

Зарлагын төсвийн зүйл ангилалд гадаад, дотоод томилолтын зардал, сургалт, семинарын зардал, төвлөрсөн арга хэмжээ (2017 оны төсөвт зөвхөн Ахмадын ойн баярын арга хэмжээнд мөнгө төсөвлөсөн), эрдэм шинжилгээний ажлын зардал (2017 оноос үүнийг хассан байна) зэрэг зайлшгүй шаардлагатай зардлууд огт тусгагдаагүй байна. Ийм нөхцөлд багш, оюутны хөгжлийг бодитой дэмжих, урамшуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд амжилт гаргах боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд учир дутагдалтай.

Цаашид тус сургуулийн төсвийг боловсруулж, батлахдаа Монгол улсын төсвийн тухай хууль, тогтоомж, санхүүгийн дүрэм, журамд заасны дагуу зардлын тодорхой зүйл ангиллаар баяжуулан, багш, оюутны хөгжлийг дэмжих тал дээр АШУУИС-ийн удирдлагын зүгээс тодорхой анхаарал хандуулах шаардлагатайг онцлон тэмдэглэе.

ШАЛГУУР 4. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

АШУҮИС-д оюутан элсүүлэхэд БСШУЯамны сайдын 2013.03.18-ны өдөр баталсан “Оюутан элсүүлэх журам”, “АШУҮИС-д оюутан элсүүлэх журам”-ыг мөрддөг байна. 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн элсэгчдийг суурь боловсролын хөтөлбөрийн сургалтанд элсүүлэн суралцуулж эхэлсэн ба 2 жил суурь сургалтанд хамруулан, тухайн суралцагчийн сонирхол, хандлага, ур чадварыг тогтоон, хөгжүүлсний үндсэн дээр Уламжлалт анагаах ухаан сургалтын хөтөлбөрөөр суралцах суралцагчийг сонгон шалгаруулж, элсүүлэн суралцуулдаг болсон нь тухайн суралцагчийн амжилттай суралцах, мэргэжилдээ дур сонирхолтой болох, цаашид үр бүтээлтэй ажиллах суурийг тавьж өгдөг сайн талтай байна. Энэхүү суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлсэнээр МАУОУС-д элсэн суралцагчийн тоо өссөн үзүүлэлттэй байна. Энэ жилийн хувьд “Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөрөөр нийт 369 оюутан элсэн суралцаж байна.

Элсэгчдийн сүүлийн 3 жилийн элсэлтийн онооны дундаж үзүүлэлт нь АСБД-д хими 642, биологи 660 байгаа нь бусад суурь боловсролын дамжаанд элсэн суралцагчдын элсэлтийн онооны дундаж үзүүлэлттэй харьцуулахад өндөр байгаа нь энэ мэргэжлийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

АШУҮИС нь шинээр элссэн оюутнуудад зориулсан, мэргэжлийн чиг баримжаа олгох “Удиртгал 07” хоногийн хичээлийг оюутны албатай хамтран явуулдаг байна. Энэхүү хичээлээр АШУҮИС-ийн салбар сургуулийн танилцуулга, сургалтын чиглэл, сургалттай холбоотой дүрэм журам, сургуулийн орчин, оюутанд чиглэсэн үйлчилгээ, сургуулийн удирдлага, мэдээллийн систем зэрэг шинэ оюутны мэдвэл зохих бүх л мэдээллийг багтаасан мэдлэгийг олгодог. Энэхүү чиглүүлэх хичээлийг 8-р сарын 28-31-ний өдрүүдэд зохион байгуулж хэвшсэн нь шинэ суралцагчийн орчин нөхцөлдөө дасан зохицох, амжилттай суралцах нэг хөшүүрэг болдог байна.

МАУОУС-ийн оюутнууд нь шинээр элсэн орсон оюутнуудыг хүлээн авч, сургууль, мэргэжлээ сурталчлах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг ба тус сургуулийн захиргаанаас шинээр элсэгчдэд анги даасан багш томилон ажиллуулдаг нь тэднийг удирдан чиглүүлэх, сурагчийн ширээнээс оюутны амьдралд хөл тавихад нь дэм болох сайн талтай байна.

Зөвлөмж: Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтанд МАУ-ын сургалтын хөтөлбөрийн онцлогтой уялдсан тусгай шаардлага, шалгуур байж болох эсэх талаар анхаарч ажиллах

4.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусласан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

МАУОУС нь оюутнуудад ахмад үеэсээ суралцах, ёс зүйн төлөвшил олгох, мэргэжлээрээ бахархах, түүний үнэ цэнийг ойлгон таниулах зорилгоор зочин профессоруудын цуврал лекц, төгсөгчидтэй эргэх холбоотой ажиллаж, тэднийг танилцуулах, тэднээс суралцах, мэргэжлээрээ бахархах, залуу залгамж халааг бэлтгэх зорилгоор төгсөгчдөө алдаршуулах уулзалтыг тус тус зохион байгуулж хэвшсэн байна.

Мөн жил бүрийн хичээлийн шинэ жилийн эхэнд “Маналын лүн хүртэх” үйл ажиллагааг бүх багш, оюутныг хамруулан явуулдаг болсон ба уг үйл ажиллагааны зорилго нь багш номоо дээдлэх, мэдээллээ мэдлэг болгох, мэдлэгээ эрдэм болгох зэрэг ач холбогдолтой байдаг нь хүмүүжлийн болон бие хүн төлөвшлийн чухал ач холбогдолтой арга хэмжээ болох нь тодорхой байна.

МАУОУС-ийн багш нар уламжлалт анагаахын дамжаа бүрийг удирдан ажилладаг бөгөөд оюутны сурлага, олон нийт, эрдэм шинжилгээний ажил, хүмүүжлийн холбогдолтой олон талт ажилд зөвлөгөө өгөх, зохион байгуулах, оюутанд ёс суртахууны хүмүүжил олгох зэрэг ажлуудыг хариуцдаг ба оюутан, хөтөлбөр, төлөвлөгөө хариуцсан тусдаа арга зүйчтэй байгаа нь энэ сургуулийн давуу тал юм.

Мөн сургалтын алба нь санал хүсэлтийн хайрцаг, асуумжийн аргаар сургууль, багш нарын үйл ажиллагаа, ёс суртахуун, сургалтын үйл ажиллагааны талаар санал хүсэлт авч, дүгнэн, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилладаг нь үйл ажиллагаандаа дүгнэлт хийх, сургалтын үйл ажиллагааг сайжруулах нэг хөшүүрэг болдог байна.

Оюутнууд бүртгэлийн дугаараараа их сургуулийн удирдлага, мэдээллийн систем болох UNIMIS программаар явцын болон шалгалтын үнэлгээтэй танилцах боломжийг бүрдүүлсэн нь бие даах, өөрийгөө дайчлах, хувийн зохион байгуулалтаа сайжруулах талаар дүгнэлт хийх боломжийг олгосон давуу талтай байна.

Оюутны сургалт, амьдрах байр, эрүүл мэндийн үйлчилгээ, номын сан, цахим үйлчилгээ зэрэг оюутанд чиглэсэн үйлчилгээг багш, эмч, ажиллагсдын тусламжтай чанартай үзүүлдэг нь оюутны нийгмийн болон эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэсэн чухал алхам болжээ.

Тус сургуулийн суралцагчид нь чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, нийгэмд чиглэсэн олон төрлийн сайн дурын ажлыг хийж хэвшсэн бөгөөд сургуулийн зүгээс төрөл бүрийн тэтгэлэг, хөнгөлөлт үзүүлдэг нь суралцагчдыг урамшуулж, цаашид амжилттай сурах итгэл найдварыг төрүүлсэн, мэргэжлээрээ бахархах, үнэ цэнийг ухааруулах ач холбогдолтой юм. Жишээ нь: сайн дурын болон олон нийтийн ажил, уралдаан тэмцээнд идэвх зүтгэл, амжилттай оролцсон оюутныг хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотод эмнэлзүйн дадлага хийх эрх, замын зардлыг МАУОУС-ийн зүгээс гаргадаг уламжлал тогтсон байна.

Тус сургуулийн оюутнууд нь “цэвэр орчин-эрүүл амьдрал” уриан дор нийтийн их цэвэрлэгээ, мод тарих, эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, талархлын аян, витаминжуулалтын аян зэрэг нийгэм олон нийтэд чиглэсэн бүтээлч, өндөр ач холбогдол бүхий олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлдэг сайхан уламжлал тогтсон байгаа нь сайшаалтай юм.

Мөн тус сургуулийн зүгээс мэргэжил сурталчлах, нарийн мэргэжлээ сонгоход нь дэмжлэг болох зорилгоор сургалт, лекц зохион байгуулж, төгсөгчдийн ажлын байрны судалгаа, ажлын байранд зуучлах үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгдөг байна. Ажлын байрны судалгаагаар 1993 оноос хойш нийт төгсөгчдийн 82.5% нь мэргэжлийн дагуу ажил эрхэлж байгаа нь сайн үзүүлэлт юм.

Тус сургуулийн тэнхмүүдийн дэргэд клуб байгуулж, судалгаа шинжилгээний ажлыг багшийн удирдлага дор хийж гүйцэтгэдэг ба жилээс жилд оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх идэвх сонирхол өссөн үзүүлэлт харагдаж байна. Жишээ нь 2016 онд 14, 2017 онд 23 эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн байна.

Зөвлөмж:

Мэргэжлийн байгууллагуудтай гэрээтэй ажиллаж, амжилттай төгсөгчдийг ажлын байранд зуучлах тогтолцоотой болох талаар санаачлагатай ажиллах

4.3 Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

АШУУИС-ийн оюутны холбооны дэргэдэх МАУОУС-ийн оюутны нийгэмлэг нь эрдэм шинжилгээ, гадаад, дотоод харилцаа, урлаг спорт зэрэг 4 дэд салбараар оюутанд чиглэсэн үйл ажиллагааг МАУОУС-ийн захирлаар батлуулсан тодорхой төлөвлөгөө удирдамжийн дагуу амжилттай эрхлэн явуулдаг байна. МАУОУСОН 2013, 2017 онуудад АШУУИС-ийн шилдэг нийгэмлэгээр шалгарч, IMSAC 2017 буюу Олон улсын анагаахын оюутны чуулганаар ЭМЯ-ны оюутны хөгжих төслийн гран при буюу тэргүүн байрыг эзэлсэн нь шилдэг хамт олон болохыг нотолсон нэг илрэл хэмээн үзэж байна.

АШУУИС-ийн оюутны холбооны жилийн төсвийг сургуулийн удирдлагаас жил бүр баталдаг ба тус холбоо нь салбар нийгэмлэг тус бүрт тодорхой тооны төсвийг урьдчилан нийгэмлэг тус бүрээс авсан саналын дагуу хуваарилдаг. МАУОУСОН нь тус төсвөөс 4 клуб тус бүртээ хувааж, сургуулийн захирлаар батлуулан үйл ажиллагааны зардалд зарцуулдаг ба үйл ажиллагааны тайланг жил бүр ном байдлаар гарган, нээлттэй мэдээлдэг нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэж байна.

Түүнчлэн АШУУИС нь оюутны байгууллагын үйл ажиллагаанд зарцуулах санхүүгийн дэмжлэгийн хувьд сүүлийн 3 жилд өмнөх жилүүдийнхээс нэмэгдүүлж ажилласан байна.

Зарцуулалтын байдлаас харахад оюутны нийгэмлэгийн чуулган, урлаг спортын наадам, оюутанд чиглэсэн аян, оюутны шагнал урамшуулал зэрэг оюутанд чиглэсэн бүхий л үйл ажиллагааны хүрээнд байна. Үүнд: 2015 оны байдлаар нийт 3037750 төгрөг зарцуулсан байна.

Зөвлөмж:

Оюутны байгууллагын үйл ажиллагааг санхүүгийн талаар дэмжих асуудлыг өргөжүүлж ажиллах

4.4 Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо
- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

АШУУИС-ийн МАУОУС-д суралцаж буй оюунлаг, авьяаслаг, тэргүүний оюутнууд, мөн амжилттай суралцаж байгаа ч амьдралын боломж тааруу суралцагчид гадаад дотоодын хувь хүн, байгууллагын 30 гаруй төрлийн тэтгэлэгт хамрагдах бүрэн боломжтой болсон нь оюутны сурах үйл ажиллагааг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлсэн байгааг харуулж байна.

2012-2016 онд МАУОУС нь шилдэг оюутанд нийт 7 төрлийн тэтгэлэг олгосон байна. 2011-2012 онд нийт 3 оюутан 1 төрлийн тэтгэлэгт хамрагдсан бол 2015-2016 онд 54 оюутан 5 төрлийн тэтгэлэгт хамрагдаж, тэтгэлэг болон хамрагдсан оюутны тоо өссөн үзүүлэлт харагдаж байна.

2017 оны байдлаар МАУОУС-ийн 8 оюутан буцалтгүй тусламж, 3 оюутан хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж, 4 оюутан бүтэн өнчиний тэтгэмж авсан байна.

МАУОУС-ийн оюутнууд сургалт, эрдэм шинжилгээ, урлаг спорт, мэргэжлийн чиглэлийн олимпиад уралдаан, тэмцээнд идэвхтэй оролцож, өндөр амжилт үзүүлдэг нь тус тайлангийн материалаас харагдаж байна. Үүнд: AMSA буюу Монголын анагаахын оюутны үндэсний анхдугаар конференцид 1 - 3-р байр, IMSAC 2017 буюу Олон улсын анагаахын оюутны чуулганаар ЭМЯ-ны оюутны хөгжих төслийн гран при буюу тэргүүн байр, “Монгол анагаах ухаан 21-р зуун” улсын оюутны эрдэм шинжилгээний хурал 2016-д тэргүүн байр зэрэг олон амжилт үзүүлсэн байна.

Мөн өмнөх магадлан итгэмжлэлээс хойш сургуулиас үзүүлж буй шагнал урамшуулал тэтгэлгийн тоо 11-30 болж нэмэгдсэн ахицтай байна.

Зөвлөмж:

Амьдралын нөхцөл тааруу, амжилттай суралцаж буй оюутанд олгох тэтгэлэг, хөнгөлөлт урамшууллын тогтолцоог дотоод нөөц боломжид тулгуурлан өргөжүүлэх талаар ажиллах

4.5 Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Оюутны шилжилт хөдөлгөөнийг АШУҮИС-ийн А/142 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 4-т заасан “Оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах” журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

МАУОУС-ийн оюутны шилжилт хөдөлгөөн 2011-2012 онд 8 шалтгаанаар 103, /мэргэжил сольсон 12/ байсан бол 2015-2016 онд 5 шалтгаанаар 30 /мэргэжил сольсон оюутан байхгүй/ болж буурсан байна. Энэ нь 2014 оноос АСБД хичээллэж эхэлсэнтэй холбоотой, мэргэжил сонголт оюутны хүсэл сонирхол, шалгалтын онооноос хамаардаг болсонтой болон уламжлалт анагаах ухаан сургалтын хөтөлбөрөөс бусад мэргэжлийн ангиуд уруу шилжих байдлыг хязгаарлах журам баримталсантай шууд хамааралтай байна.

ЭМШУИС-ийн захирлын А/66 тоот тушаалд гадаад, дотоодын ижил мэргэжлийн их, дээд сургуулиас шилжин суралцах оюутны сурлагын голч дүн 3.0 ба түүнээс дээш гэж заагдсан байсан бол АШУҮИС-ийн захирлын А/142 тоот тушаалаар 2.8 ба түүнээс дээш гэж өөрчилсөн нь оюутныг тус сургуульд шилжин суралцах боломжийг нээсэн, эрх ашигт нийцсэн шийдвэр болсон байна.

Зөвлөмж:

ШАЛГУУР 5. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1 Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал

-
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Багш бэлтгэх, сонгон шалгаруулах, ажилд авах асуудал нь АШУҮИС-ийн захирлын 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/118 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагааг зохицуулах журмын гуравт заасны дагуу зохицуулагдаж байна. Мөн АШУҮИС-ийн багшийн алтан дүрэм буюу багш хөгжүүлэх тулгуур баримт бичгийг 2014 онд боловсруулан мөрдөж байна.

Багшийн үйл ажиллагааг нэгдсэн журмаар зохицуулах үүднээс багштай холбоотой бүх журмыг нэгтгэн шинэчлэн боловсруулах, багшийн эрх, үүрэг, багшийн ажлын хариуцлага, багшийн хөгжлийн асуудалд голлон анхаарснаар өмнө нь шинэ багшийн сонгон шалгаруулалт, багшийн ажлын үнэлгээ, аттестатчлал, багшийн ажлын гүйцэтгэлийн журмын нэгдмэл байдлыг тодорхой хэмжээгээр хангаж чадсан байна. Шинээр багшийг ажилд сонгон шалгаруулах үйл ажиллагааг тэнхимийн хурал, харьяа сургуулийн сургалтын алба нэгжээр хэлэлцүүлэн, ноогдох цагийн ачааллын нь тооцон, саналаа Сургалтын бодлого зохицуулалтын Газрын (СБЗГ) Багшийн хөгжлийн төвд хүргүүлэх бөгөөд тус төвөөс тухайн ажлын байрны зарыг 21 хоногийн хугацаатай мэдээллийн хэрэгслээр ил тод, нээлттэй зарладаг зэрэг нь хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого, багшийн сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилтийн хувьд нэгдсэн цогц бодлого, механизмтай байгаагийн илрэл гэж үзэж болно.

2010-2011 оны хичээлийн жилд МАУОУС-ийн багш нарын 20% нь докторын зэрэгтэй байсан бол 2016-2017 оны хичээлийн жилд тус сургуулийн багш нарын 79% нь докторын зэрэгтэй болж нэмэгджээ. Энэ нь БСШУС-ын 2010 оны 26 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын 3.3-д заасан үндсэн багшийн 15-аас доошгүй хувийг докторын зэрэгтэй байна гэсэн шаардлагыг хангаж байна.

2016-2017 оны хичээлийн жилд уламжлалт анагаах ухааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын албан тушаалын зэрэглэлийг 2010-2011 оныхтой харьцуулахад ахлах багш, багшийн эзлэх хувь 19.3%-аар буурсан, харин дадлагажигч багшийн тоо 16%-аар, профессор, дэд профессор 16.3%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нэг багшид ноогдох оюутны тоог бууруулж, сургалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд багш, оюутны тооны харьцаа 2013 онд 1:20-21 байсан, одоо бол 1:14-15 болсон байна. Цаашид уг харьцааг 1:12 болгоно гэсэн зорилттой байна.

АШУҮИС-ийн профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн орон тоон дээр ажиллаж байгаа багшийн гүйцэтгэх ачааллыг албан тушааллын зэрэглэлээс хамааруулан ялгавартай байдлаар тогтоожээ.

АШУҮИС-ийн захирлын 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/109 тоот тушаалаар Багшийн ажлын гүйцэтгэлтэй холбоотой урамшууллын үнэлгээг шинэчлэн баталсан байна.

Зөвлөмж:

Багшийг сонгон шалгаруулахдаа мэргэжил (60%), гадаад хэлний мэдлэг (40%)-ээр нь сорил, ярилцлага хэлбэрээр шалгалт авахын зэрэгцээ заах арга, ур чадвар, хувь хүний соёл, бүтээлч байдал ба шинийг санаачлах, асуудал шийдвэрлэх, харилцаа, хамтын ажиллагаа, мэдээллийн технологитой ажиллах, эмнэлзүйн туршлага зэрэг чадваруудыг харгалзан тооцдог байх нь зүйтэй.

5.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүй, суралцах хэрэгцээг тодорхойлох судалгаа, хэлэлцүүлгийг их сургуулийн хэмжээнд цахим санал асуулга байдлаар авч үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлдэг байна.

2016-2017 оны хичээлийн жилд Багш хөгжлийн төвийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан МАУОУС-ийн багш нарт зориулсан сургалт, эмнэлзүйн багш нарт зориулсан PBL сургалт, судлаач багш сургалт, шинэ багш нарт зориулсан сургалт, байгууллагын соёл зэрэг сургалтуудад багш нар хамрагдсан байна. АШУҮИС-ийн Багшийн хөгжлийн төвөөс багшийг 4 чиглэлээр хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг боловч уг хөтөлбөрөөр багш нар хэдийд, ямар хугацаатай сургалтад хамрагдаж, түүний үр дүнд багш нар хэрхэн хөгжсөн, ажлын бүтээмж, чанарт ямар өөрчлөлт гарсан зэрэгт дүн шинжилгээ хийх механизм дутмаг байна.

Төсөвт хэдийгээр гадаад, дотоод томилолтын зардал тодорхой тусгагдаагүй боловч багшийг хөгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд багш, оюутан солилцоо, сургалтын хамтарсан хөтөлбөрүүд, гадаадын зарим их, дээд сургуулиудад хичээл заах, лекц унших зэрэг ажлуудад тодорхой хэмжээгээр хамрагджээ.

Зөвлөмж:

Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдлыг тодорхой чиглэлүүдээр тоочин нэрлэхээс гадна сүүлийн жилүүдэд энэ чиглэлд тооны болон чанарын ямар ахиц, дэвшил болон бууралт гарсан зэрэгт дүн шинжилгээ хийж, цаашдын үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх хэрэгтэй.

5.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

МАУОУС-ийн багш нарын боловсруулсан шинэ бүтээлийн патент, стандарт, технологийн загваруудаас нэрлэвэл:

Патент, ашигтай загварын гэрчилгээ: Шинэ бүтээлийн нэр: Ямаан сэрдэг ургамлаас элэг хамгаалах, цөс хөөх үйлдэлтэй хуурай ханд бэлтгэх, хэрэглэх арга. Сэр-Од Хишигжаргал. №4147. Монгол улсын оюутны өмчийн газрын 2014 оны 12 дугаар тушаал.

Стандарт, бүртгэлийн гэрчилгээ: Биологийн идэвхит бүтээгдэхүүн. “Остео кальци-5” капсултай бэлдмэл. Техникийн шаардлага. MNS 6467:2014, Биологийн идэвхит бүтээгдэхүүн. “Остео кальци-6” капсултай бэлдмэл. Техникийн шаардлага. MNS 6468:2014 зэрэг стандартуудыг Стандартчилал, хэмжилзүйн газраар батлуулсны дээр уг Биологийн идэвхит бүтээгдэхүүний бүртгэлийн гэрчилгээг Монгол улсын Эрүүл мэнд, Спортын Яамнаас авсан байна. Эдгээр гэрчилгээний бүртгэл нь 2020 оны 02 дугаар сарын 12 өдөр хүртэл хүчинтэй байна.

МАУОУС-ийн багш нарын захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдлын тухайд 2010 оноос суурь судалгаа болон инновацийн, захиалгат төсөлд нэлээд идэвхтэй бөгөөд амжилттай оролцсон байна. Эдгээрээс дурдвал:

- “Монголын уламжлалт анагаах ухааны эм, бэлдмэл зарим нийлмэл жорын бактери, вирусын эсрэг үйлчлэлийг тогтоох фармакологийн судалгаа” төсөл
- “Жоншноос эмийн уламжлалт технологийн аргаар биологийн идэвхит бэлдмэл гарган авах” инновацийн төсөл
- “Архаг пиелонефрит өвчнийг орчин үеийн болон УАУ-ны аргаар эмчилж үр дүнг харьцуулан судлах нь” төсөл
- “Уламжлалт эмт бодис, шинэ эмийн хими-фармакологи, эмнэлзүйн судалгаа”
- “Цусны даралт ихсэх өвчнийг уламжлалт зүү, эмийн эмчилгээний аргаар эмчлэх асуудалд” төсөл
- “Ходоод улаан хоолойн хавдрын эсийн өсгөвөрт жоншны үнс нөлөөлөх нь” төсөл
- Өвөр Монголын олон улсын эмнэлэгийн хороотой хамтарсан “Хөгшрөлтийн эсрэг, урт наслуулах эмийн ургамлын судалгаа, шинэ эмийн бэлдмэл гаргаж авах технологи”, “Уламжлалт анагаах ухааны түүхэн эх сурвалжийн судалгаа”, Япон улсын Гүнмагийн Их Сургуультай хамтарсан “Монгол хүний генийн полиморфизмын судалгаа болон улаан хоолой, ходоодны хорт хавдрын эсрэг уламжлалт эмийн судалгаа” зэрэг төслүүд хэрэгжиж байна.

МАУОУС нь Ази, Европын ижил, төстэй сургалтын хөтөлбөрийн агуулгыг тодорхой хэмжээгээр тусгасан, хөрвөх чадвартай, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх УАУ-наар мэргэжилтэн бэлтгэн гаргах зорилгоор гадаадын 8 орны 12 их, дээд сургуультай багш, оюутан солилцох, мэргэжилтэн бэлтгэх, сургалт-семинар, төсөлт ажил, эрдэм шинжилгээ, судалгаа, ном сурах бичиг солилцох зэргээр сургалтын агуулга, арга зүй, судалгааны ажлыг хөгжүүлж байгаа нь шинэлэг бөгөөд бүтээлч ажлын илрэл, үр дүн гэж үзэж болно.

Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг төгсөлтийн дараах магистрантур, докторантурын сургалтын хөтөлбөрт тусган, лекц, семинарын хичээлээр 2016 оноос ордог болжээ.

2011-2016 онуудад МАУОУС-ийн багш нар өөрийн улсын болон олон улсын нэр хүнд бүхий хэвлэлд нийт 244 бүтээл хэвлүүлсэн бөгөөд үүнээс үндэсний хэвлэлд 193, олон улсын хэвлэлд 51 бүтээл хэвлүүлсэн байна.

Зөвлөмж:

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэн хөгжүүлэх үүднээс төсөв тодорхой тусгадаг байх шаардлагатай.

5.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ / аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах / заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Дүгнэлт:

АШУУИС-ийн захирлын 2016 оны 06 дугаар сарын 10 өдрийн А/72 тоот “АШУУИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”-ын дагуу МАУОУС-ийн багш нарыг үнэлж, дүгнэдэг байна.

Багшийн ажлыг үнэлэх стандартын дагуу багш бүр өөрийн үнэлгээний тайлан бичиж, СБЗГ-ын харьяа Багшийн хөгжлийн зөвлөлөөр үнэлүүлнэ. Багшийн хөгжлийн зөвлөл нь багшийн өөрийн үнэлгээний тайланг нотлох баримтад тулгуурлан үнэлэх бөгөөд уг үнэлгээ нь багшийн албан тушаалын зэрэглэл дэвших, буурах үндэслэл болохын зэрэгцээ мөн хөдөлмөрийн гэрээг сунгах, цуцлах үндэслэл болдог байна.

Багшийн ажлыг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн 3 үндсэн чиглэлээр 100 оноогоор дүгнэнэ. Эдгээр нь багшийн албан тушаалын зэрэглэлээс хамааран өөр өөр онооны шалгууртай.

Багшийг 3 жил тутамд аттестатчлах бөгөөд ажлын гүйцэтгэлийн үр дүнг “сайн”, “дунд зэрэг”, “хангалтгүй”, “маш хангалтгүй” гэсэн шалгуураар оноожуулан үнэлэх бөгөөд “хангалтгүй” үнэлгээ авсан багш нь багшийн өөрийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх ба түүний хэрэгжилтэд салбар, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд, Багш хөгжүүлэх зөвлөл хамтран хяналт тавин ажилладаг байна. 2016-2017 онд 2 багш 60-70 оноо буюу ажлын гүйцэтгэл, үр дүн “хангалтгүй” (тухайн албан тушаалд нэг жил ажилласны дараа дахин аттестатчлалд орох) үнэлгээ авчээ.

Төгсөлтийн өмнөх сургалтын албанаас боловсруулсан үлгэрчилсэн асуулгын хуудсаар оюутнуудаас санал авах ба энэ нь багшийн аттестатчлалын үнэлгээний

нэг шалгуур болж, 10 оноог бүрдүүлж байгаа нь сургалтад оролцогчдоор багшийн ажлыг үнэлүүлж байгаагийн илрэл гэж үзэж болно.

Багш бүр ажлын хавтастай, хавтас нь тэнхим тэнхимээр өнгөөр ялгаатай ба үндсэн хэсэгт эрх зүйн баримт бичгүүд, сургалтын хэсэгт өөрийгөө хөгжүүлэх сургах, заах аргын материал гэх мэт багшийн бүхий л үйл ажиллагааны нотлох баримт, материал цэгцтэй болсон байна.

Зөвлөмж:

Сургалтад ашиглаж буй сургах, заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа маш дутмаг байна. Багш бүрийн хичээлийн хөтөлбөрт байгаа сургах, заах аргууд нь хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүн (оюутанд эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлага)-д хэр нийцтэй, үр өгөөжтэй болох, багш уг аргуудыг сургалтад хэр оновчтой, бүтээлчээр ашиглаж байгаа зэрэгт тэнхим, хөтөлбөрийн албаны зүгээс тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлж хэвших нь хөтөлбөрийн хэрэгжилтэд эерэгээр нөлөөлнө.

ШАЛГУУР 6. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой болох нь харагдлаа. Одоогийн хэрэгжүүлж буй АШУҮИС-ийн захирлын 2015.12.14-ний А/142 тоот тушаалаар баталсан МАУОУС-ийн УАУ сургалтын төлөвлөгөөний дагуу 2 жил АУ-ы суурь боловсролын 68 багц цагийн хичээлүүдийг судалж, ерөнхий мэргэжлийн хичээл 53 /47,9%/, мэргэжлийн суурь хичээл 45 /23,9%/, мэргэшүүлэх суурь хичээл 90 /28,2%/, дадлагажих 10 тус тус орж урьдах сургалтын хөтөлбөрөөс 5% илүү мэргэшүүлэх хичээлийн сургалтыг нэмэгдүүлэн мэргэжлийн ур чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд чиглүүлсэн байна.

Сургалтын хөтөлбөр нь сургалтын олон давуу талуудтай асуудлыг шийдвэрлэх, сургалтыг дадлага эмнэлзүйн практикт ойртуулсан, оюутны бие даан суралцах өөрийгөө хөгжүүлэх, оюутан төвтэй сургалтанд шилжсэн, олон мэдээллийг нэгтгэн хоорондын уялдаа холбоог сайжруулсан, оюутанд насан туршийн өөрөө бие даан суралцах арга барилыг эзэмшүүлж чадаж байна. Өөрөөр хэлбэл, сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байна гэж үзлээ.

УАУ-ны бакалаврын сургалтын төлөвлөгөө нь нийт 68+130 багц цаг ба түүнээс нийт сонгон суралцах 14 хичээл бүхий 32 багц цагийн хичээл, бүхий нийт суралцах 16 нэр төрлийн хичээл бүхий 32 багц цагийн хичээл уламжлалт заслын анги нь нийт сонгон суралцах хичээл бүхий 12 багц цагийн хичээл судлах боломжтой байна.

УАУ-ны сургалтын хөтөлбөр нь онолын болон дадлагын хичээлийг зохистой харьцаагаар судлахаар зохион байгуулсан бөгөөд хичээл тус бүр лекц, дадлага, бататгах цагийг багтаасан байна.

Мэргэжил нэгт улс орнуудын оюутнуудын суралцах арга зүй, тэдний шинэлэг ололттой талыг сургалтандаа ашиглах, харилцан туршлага солилцох үүднээс Солонго багш 2014.10 сард 15 оюутан-Хөх хотод дотор өвчний, Оюунцэцэг багш 2015. 10 сард 18 оюутныг заслын хичээлийн дадлага Ордосын АУС дээр, Сээсрэгдорж багш 2015. 11 сард дотор өвчний дадлага, Байгалмаа багш 2016. 07 сард эмийн дадлага удирдсан байна. 2011 онд Тунляогийн УИС-тай, Японы Арике анагаах ухааны сургуультай уламжлалт засалч 2+4 бэлтгэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна.

Зайны болон цахим хичээлүүдийг E-контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал – Зарим сонгон суралцах суурь хичээлүүд, лекц, зүү эмчилгээний зүүний байршил зүйн 10 гаруй бичлэг, бариа заслын видео бичлэг, 300 гаруй эрүүл болон өвчин эмгэгийн хэл оношилгооны дижитал зураг, 30 гаруй шээс оношилгооны зураг, хийн дасгал, төв номын санд 4258 цахим ном, мултимедиа 9805, эрдмийн бүтээл 1095, цахим лекц 226, цахим сэтгүүл 3, сэтгүүлийн 38 дугаарын 1710 өгүүлэл байна.

Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдлыг-1-2 дамжааны суурь хичээлүүд, 3-6 дамжаанд мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийг судалж байгаа нь сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээлүүд нь хоорондоо нягт уялдаж өгсөн байна.

Зөвлөмж:

Өмнөх магадлан итгэмжлэлийн зөвлөмжөөр өгч байсан сургалтыг судалгаа, эрдэм шинжилгээний ажилтай холбож заах, өөрөөр хэлбэл “судалгаа-сургалт-эмнэлэг, үйлчилгээ” гэсэн шатлалын доторх судалгаа шинжилгээ гэсэн тэргүүлэх үйл ажиллагаанд ач холбогдол өгч судалгаанаас гарсан үр дүнгээ сургалтанд нэвтрүүлэх, өөрийн орчинд биеэ даасан эрдэм шинжилгээний төвтэй болоход анхаарч ажиллахыг зөвлөж байна.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар

-
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
 - Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
 - Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Уламжлалт анагаах ухааны сургалтын арга зүй нь нэг талаас багшийн чиглүүлэх арга нөгөө талаас оюутны суралцах аргыг нэгтгэсэн үйл ажиллагаа бөгөөд сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй байна.

УАУ-ны хөтөлбөрт оюутныг бие даан хөгжихөд чиглэгдсэн сургалтын “SPICEST” загвар сургалтын дэвшилтэт арга технологи болох асуудалд суурилсан сургалт, дадлага явуулах эмнэлзүйн эмнэлгийн орчин, интерактив лекц, тохиолдолд суурилсан сургалтыг амжилттай хэрэгжүүлж байна

Багшийн чиглүүлэх үйл болон оюутны сурах арга нь хоорондоо уялдаатай гүйцэтгэх эрэмбэ дараалалтай байна. Үүнд: сургалтын арга зүйд цээжлүүлэх, тайлбарлах, ном хаялцах /идэвхжүүлэх/, бие даан суралцах, дадлагажих зэргийг ашигладаг бөгөөд МАУОУС-ийн IV, V, VI дамжааны оюутнуудаас судалгаа авахад 82,2% нь сургалтын хөтөлбөрийн эрхэм зорилтыг хангалттай сайн, 80% нь амьдрал практиктай уялдуулан хэрэгцээ шаардлаганд тулгуурласан хэмээн үнэлснээс үзэхэд сургалтын арга зүй нь суралцагчдийн эрэлт, хэрэгцээнд нийцэж байна.

Мөн судалгаагаар ажил олгогч байгууллагын хичээлийн агуулгыг эмнэлзүйн практиктай холбох шаардлагатай улмаас оюутнуудаас багшийн заах арга зүйд хичээлийг амьдрал практиктай уялдуулдаг асуумжийн судалгаагаар 80% нь дунд зэрэг гэж үнэлсэн байгаа нь эмнэлзүйн хичээлүүдийг клиникийн орчинд эмнэлэг дээр үйлчлүүлэгчдэд чиглэсэн тохиолдол хэлбэрээр явуулах, эмнэлзүйн багш нарын заах арга зүйг сайжруулах зорилгоор багш хөгжлийн төвийн эмнэлзүйн сургалтанд 3 багш, Койко хамтарсан төслийн хүрээнд эмнэлзүйн заах арга зүйн семинарт 5 багш оролцсон байгаа нь судалгааны үр дүнгээр арга хэмжээ авдаг болох нь харагдаж байна

Зөвлөмж:

- Сургалтын арга зүй болон сургалтанд хэрэглэж буй мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи программ хангамж техник хэрэгслийг сайжруулах
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь суралцагчдын мэдлэг чадвар, хөгжлийн түвшинд хэр нийцэж байгаа болон багш нар сургалтад мэдээлэл харилцааны технологи, программ хангамжийг хэр зэрэг бүтээлчээр ашиглаж чадаж байгаа зэрэгт дүн шинжилгээ хийх

6.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

-
- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
 - Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал
 - Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
 - Суралцагчийн гаргаж буй амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Суралцагчийн үнэлгээг тухайн оюутан урьдчилан тодорхойлсон чанар, чадварт хүрсэн эсэхийг баталгаажуулах, дараагийн түвшинд дэвшин суралцах шаардлага хангасан, эсвэл хөтөлбөрийг дахин давтан судлах шаардлагатай байгаа оюутнуудыг олж тогтоох, тухайн сургалтын хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн суралцагчдыг сурлагаар нь эрэмбэлэх сурах зөв хандлагыг урамшуулах, оюутнуудад өөрсдийнхөө сурлагад хяналт тавих боломж олгох, оюутнуудад ололт амжилтын талаар мэдээлэлтэй болох, оюутны тулгамдсан асуудлыг илрүүлэх, оюутнуудын давуу болон сул талуудын талаарх гүйцэтгэлийн мэдээллийг бий болгох зорилгоор үнэлдэг юм байна.

Оюутны мэдлэг чадвар хандлагыг “Суралцагчийг үнэлэх журам”-ын дагуу А, В, С, Д, F гэсэн үсгэн дүн болон процентон дүн хэрэглэнэ. Хичээлийн төгсгөлийн процентон дүн нь явцын болон шалгалтын дүн гэсэн хоёр хэсгээс бүтнэ. Төгсгөлийн дүнд эзлэх явцын болон шалгалтын дүнгийн харьцаа 70:30 байна. Эмнэлзүйн сургалтын өвчтөн үзэх, өвчний түүх бичих, гардан үйлдлийн ур чадвар, жижүүр хийх, эмнэлзүйн ярилцлага, харилцаа хандлага, эмнэлзүйн тохиолдол шийдвэрлэх байдал зэргийг явцын дүнд тусгана. Хичээлийн явцын дүнд “үл тооцов” үнэлгээ авсан тохиолдолд ноогдох цагийн хөлсний 50%-ийг төлж нөхөн суралцдаг Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг харгалзан шалгалтын дараах арга хэлбэрүүдээс тохиромжтойг нь сонгоно, **Мэдлэг үнэлэх шалгалт** – аман шалгалт, эссэ бичих бичгийн шалгалт, олон хувилбарт сорил /А, К, В, Е хэлбэр/, компьютерт суурилсан сорил /Е-сорил/ эмнэлзүйн тохиолдолд суурилсан сорил, **Ур чадвар үнэлэх шалгалт** – ТЭЭШ ТЭГШ, өртөөчилсэн шалгалт, урт болон богино хэлбэрийн эмнэлзүйн тохиолдол, гардан шалгалт, өвчний менежмент, Цогц чадамжийг үнэлэх шалгалт – ТЭЭШ, ТЭГШ, 360 хэм үнэлгээ /зөвхөн хандлага, харилцааг үнэлнэ/ эмнэлзүйн дасгал үнэлгээ /mini-CEX/, гардан гүйцэтгэлийн ажиглалтын үнэлгээ /DOPS/, Портфель үнэлгээгээр үнэлэгдэг юм байна. Монгол улсад уламжлалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн болон улсын төв эмнэлгүүдийн ажил олгогч нараас асуумж судалгаа авахад УАУ сургалтын хөтөлбөрөөр төгссөн их эмчийн ажлын байранд ажиллах шаардлагад 100% сайн нийцдэг, 97% нь мэдлэг сайтай, 80% нь ур чадвар сайтай гэж үнэлсэн байна

Уулзалтын үеэр оюутнууд сургалтын үнэлгээнд сэтгэл ханамжтай, бодит байдаг гэж үзэж байгаа нь оюутны үнэлгээ нь оюутанд нээлттэй, ил тод, өөрийн сурлагын амжилт чанарыг мэдэх, хянах боломжтой болохыг шинжээчдийн баг ахиц дэвшил болжээ гэж үнэллээ.

Зөвлөмж:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга түүнийг байнга сайжруулах тал дээр анхаарч хяналт тавих
- Цаашид тэнхим бүр хичээл бүрээр сурлагын үнэлгээн дээр анализ хийх

ШАЛГУУР 7. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1 Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
Сэтгэл ханамжийн судалгааг хичээл бүрээр авдаг.
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Дүгнэлт:

1993 оноос 2016 он хүртэлх хугацаанд тус сургуулийг уламжлалт анагаах ухаан сургалтын хөтөлбөрөөр 816 эмч төгсчээ. Эдгээрийн 673 буюу 82.5% нь ажил эрхлэж байна.

Ажил эрхлэж буй төгсөгчдийн 391 буюу 58.1% нь уламжлалт анагаах ухааны чиглэлээр, 148 буюу 22% нь уламжлалт анагаах ухаанаас бусад эрүүлийг хамгаалах салбаруудад ажиллаж байна. Ажил эрхлэгчдийн 16.5% нь эрүүлийг хамгаалахаас бусад салбарт ажиллаж байна. Энэ нь дараах нөхцөл байдалтай холбоотой гэж үзэх үндэслэлтэй байна.

- Монгол улсын хэмжээнд уламжлалт анагаах ухааны чиглэлээр эмч бэлтгэх их, дээд сургуулийн тоо нэмэгдсэн.
- Хөдөө, орон нутагт уламжлалын эмчийн орон тоо бага зэрэгтэй холбоотой байна.

Төгсөгчид ажлын байранд гараад ямар мэдлэг, чадвар шаардлагатай байгаа талаар ажлын байрны нийцлийн судалгааг явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлж байгаа талаар өмнөх 1-р шалгуурт дурдсан.

МАУОУС-ийн төгсөгчдийн харилцаа, хандлага, мэдлэг чадварыг үнэлэх судалгаанд нийт 20 эмнэлгийн 30 удирдлага оролцсноос бүгд МАУОУС-ийн төгсөгчдийг уламжлалт анагаах ухааны эмчийн ажлын байрны шаардлагад нийцдэг, 97% нь мэдлэг сайн, 80% нь ур чадвар сайн, 24% нь шинэ төгсөгчийн хувь хүний бие даан ажиллах чадвар дунд, ажлын байранд эмчийн ёс зүйн буюу эмч эмнэлэгийн ажилтны харилцаа, хандлагын алдаа гаргадаг гэж дүгнэсэн байна.

Төгсөгчид, ажил олгогчдын төлөөлөлтэй уулзалт хийх үед дээрх судалгааны дүн үнэн бодитой болох нь ажиглагдсан бөгөөд тэд: “АШУҮИС – ийн УАУ – ы сургуулийг төгссөн хүмүүсийн мэргэжлийн ур чадвар, хүний биеийн эрүүл ба эмгэг үйл ажиллагаа, түүний зүй тогтол, эрхтэн тогтолцооны харилцаа холбоо, өвчний шалтгаан, нөхцөлийн

талаар онолын мэдлэг өндөр, хүнтэй харилцах чадвар, хандлага сайн..." хэмээн үнэлж байв.

Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртлээ зарцуулах дундаж хугацааг улсын болон хувийн хэвшлийн эмнэлэг, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллагсдаас асуумж судалгааг авсан байна. Уг судалгаагаар 1993 оноос хойш төгсөгчдийн 34.6% нь төгссөн даруйдаа, 3.8% нь 1 сарын дотор, 11.5% нь 3 сарын дотор, 7.6% нь 6 сарын дотор, 11.5% нь 1 жилийн дотор, 11.5% нь 2 жилийн дотор, 3.8% нь 5 жилийн дотор ажлын байраар хангагдсан бөгөөд 7.6% төгсөөд 9 сарын хугацаа өнгөрч байхад ажлын байраар хангагдаагүй байна.

Зөвлөмж:

Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны хэсэгт МАУОУС-ийн IV, V, VI дамжааны оюутнуудаас авсан нь шалгуурт төдийлөн нийцэлгүй байна. Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах хугацааг 1993 оноос ерөнхийлөн гаргах бус тодорхой оны үечлэлээр, ялангуяа сүүлийн 5 жилээр харьцуулан гаргах нь бодит дүн шинжилгээ хийхэд дөхөмтэй байж болно.

Уламжлалтын эмч хүн бодит амьдрал дээр зөвхөн уламжлалтын эмч хийдэггүй орчин үеийн анагаах ухааны чиглэлээр оношилгоо, эмчилгээ явуулдаг тухай төгсөгчид, ажил олгогчдын ярианд олонтаа дурдагдаж байсан тул уламжлалтын эмч нарыг нарийн мэргэжлээр сургах үүднээс төгсөлтийн дараах сургалтыг уламжлалтын дотрын, мэдрэлийн, хүүхдийн, гэмтлийн, эмэгтэйчүүдийн гэх мэтээр дагнасан чиглэлээр хөгжүүлэхэд анхаарах.

7.2 Хөтөлбөрийн үр нөлөө

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

МАУОУС-ийг 1993 оноос хойших төгсөгчдийн төрийн шагнал, урамшуулал хүртсэн байдлыг судалгаагаар гаргажээ. Үүнд: Алтан гадас одонгоор 4, Хөдөлмөрийн хүндэт медалиар 2, Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтнаар 31, Шинжлэх ухааны тэргүүний ажилтнаар 2, Боловсролын тэргүүний ажилтнаар 2, ЭМСЯ-ны Хүндэт жуух бичгээр 32, МЗХ-ны тэргүүний залуу алтан медалиар 16 төгсөгч шагнуулсан байна. Нийт төгсөгчдийн эрдмийн зэрэг, цол хүртсэн байдлын тухайд академич 1, профессор 2, дэд профессор, клиникийн профессор 6, АШУ-ны доктор 1, АУ-ы доктор 35, АУ-ны магистр 78 байна.

Нийт төгсөгчдийн 6.7% нь их, дээд сургуулийн захирал, хувийн хэвшлийн эмнэлэгийн дарга, эрдэм шинжилгээний байгууллагын захирал, аймаг, сум, дүүргийн нэгдсэн эмнэлгийн дарга, менежер эмнэлэгийн тасгийн эрхлэгч, нэгжийн эрхлэгч,

эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компанийн захирал, зөвлөх, менежер зэрэг удирдах албан тушаал хашиж байна. Мөн нийт төгсөгчдөөс 17 нь мэргэжлийн чиглэлээр хувийн хэвшлийн эмнэлэг, компанийг байгуулан, амжилттай үйл ажиллагааг явуулж байгаагийн дээр тус сургуулийн төгсөгчдийг тодорхой хэмжээгээр ажлын байраар хангаж байгаа явдал нь төгсөгчдийн зүгээс сургуультайгаа эргэх холбоо сайтай ажиллаж байгаагийн илрэл, нотолгоо болж байна.

Мөн нийт төгсөгчдийн 4.3% нь Польш, ОХУ, АНУ зэрэг гадаадын улс орнуудад Монголын уламжлалт анагаах ухааныг дэлгэрүүлэн сурталчлах үйл ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулж байна.

Зөвлөмж:

Цаашид тус сургууль төгсөгчдөөс мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмрийг тодорхойлох, үнэлэх судалгааг төрийн болон ТББ-ын зүгээс хийлгэх нь зүйтэй.

7.3 Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжилт
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

БНХАУ-ын Тунляо хотын Өвөр Монголын Үндэсний их сургууль, Ордос хотын Анагаах ухааны сургууль, Хөх хотын АУИС, Монгол эм эмнэлгийн дээд сургууль, Тяньжин хотын Хятад АУИС, Япон улсын Эрүүл мэндийн шинжлэх ухааны Токио Ариаке Их сургууль, Гүнмагийн их сургууль, Бутаны Вант улсын Кесар Гяалпо Анагаахын Шинжлэх Ухааны Их Сургуультай хамтарсан оюутан солилцоо, уламжлалт анагаах ухааны чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, хамтын ажиллагааны олон талт ажлыг хэрэгжүүлж байна. МАУОУС-д БНХАУ, Япон улс, Бутанаас нийт 58 оюутан төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтад хамрагдаж байна. Эдгээрээс бакалаврын түвшинд 18, магистрын түвшинд 24, докторын түвшинд 16 оюутан суралцаж байна.

МАУОУС нь АНУ-ын Дорно дахины анагаах ухааны дээд сургууль, БНСУ-ын Дэгү их сургууль, Дорно дахины анагаах ухааны хүрээлэн, ОХУ-ын дорно дахины анагаах ухааны төв, Японы рашаан судлалын нийгэмлэг, Саппорогийн олон улсын их сургууль, Мэйжигийн олон улсын их сургууль, БНХАУ, Бутан зэрэг улс орнуудын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүдтэй хамтарсан хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд Японы Ариаке их сургуультай Уламжлалт анагаахын засалч мэргэжилтэнг бэлтгэх, БНХАУ-ын уламжлалын чиглэлийн их, дээд сургуультай “Уламжлалт анагаах ухааны их эмч бэлтгэх” зэрэг чиглэлээр эрчимтэй хамтран ажиллаж байна. Ялангуяа эдгээр улс орны

зүгээс МАУОУС-д хөрөнгө санхүүгийн болон эмнэлэгийн сүүлийн үеийн техник, багаж хэрэгслийг ханган нийлүүлж байгаа нь тус сургуулийн сургалтын орчинд бодит дэмжлэг, тусламж болж байна.

Тус сургуульд суралцагч оюутнууд улсын болон олон улсын чанартай уралдаан, тэмцээнд амжилттай оролцож байгаа бөгөөд эдгээрийн дийлэнх нь спорт, урлагийн тэмцээнд үзүүлсэн амжилтууд эзэлж байна. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр сүүлийн жилүүдэд оюутан суралцагчид эрдэм шинжилгээний хуралд оролцож, амжилт үзүүлж байгаа нь сайшаалтай байна.

МАУОУС-ийн төгсөгчид АНУ, Англи, БНСУ, Япон, Герман, ОХУ, Австрали, БНХАУ, Польш зэрэг улс орны их, дээд сургуульд ахисан түвшний сургалтад хамрагдсан талаар тайланд тодорхой мэдээлэл байна. Гэвч эдгээр нь олон улсдаа магадлан итгэмжлэгдсэн эсэх талаар мэдээлэл байхгүй байна.

Зөвлөмж:

Гадаадын оюутан суралцагчдад зориулсан тусгайлан сургалт, зөвлөгөө, арга зүйн дэмжлэг дутмаг байгаа талаар зарим оюутны ярианд дурдагдаж байсныг цаашид анхаарч ажиллах шаардлагатай. Ялангуяа Өвөр Монголоос ирсэн оюутан суралцагчид кирилл бичгээр уншиж, бичихэд бэрхшээл үүсдэг талаар өгүүлж байсан. Гадаадын оюутан суралцагчдыг монголын сургалтын орчин нөхцөлд дасан зохицоход нь бусад үе тэнгийн монгол суралцагчдын нөхөрсөг, дотно тусламж дэмжлэг бүхий харилцааг бий болгох тал дээр оюутны хөгжлийн алба болон хөтөлбөрийн албаны зүгээс тодорхой бүтээлч ажлуудыг зохион явуулдаг байх хэрэгтэй. Энэ нь цаашид гадаад оюутны тоог нэмэгдүүлэхэд ч эерэг нөлөөтэй.

7.4 Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Веб сайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

Хөтөлбөрийн үйл ажиллагааг цахим, веб хуудсаар дамжуулан ил тод олон нийтэд түгээн сурталчлах талаар ЕБС болон бусад байгууллага, ард иргэд, гадаадын зарим улс оронд зохион явуулдаг байна.

АШУҮИС-ийн веб сайт www.mnums.edu.mn цахим хуудас дахь МАУОУС-ийн цэсэнд МАУ-ны хөгжлийн шинэ үе шатны зураглал болон тус сургуулийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, эрх зүйн шинэчлэл, бодлогын баримт бичиг, 2016 оны бүтээн байгуулалт, хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн зураглал, гадаад харилцааны тухай танилцуулга, мэдээлэл оруулсан нь бусад бүрэлдэхүүн сургуулиас онцлогтой байна.

Зөвлөмж:

Сургуулийн веб хуудсаар олон улсад хөтөлбөрийн үйл ажиллагааг сурталчлах, хөтөлбөрийн талаар хамтран ажиллаж буй гадаадын зарим улс орны хэлээр танилцуулга бэлтгэх, байршуулах, веб хуудсанд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж, албадын байнгын үйл ажиллагаагаар баяжуулан, хэрэглээнд оруулах талаар түлхүү анхаарч ажиллах

ШАЛГУУР 8. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1 Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажууллыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Дүгнэлт:

АШУҮИС-ийн бүх мэргэжлийн хичээлийн хөтөлбөрийг дэлхий нийтийн дээд боловсролын ерөнхий чиг хандлагад дүйцүүлэх зорилгоор тус сургуулийн захирлын тушаалаар батлагдсан “Хөтөлбөр боловсруулах мэргэжлийн баг” томилогдон ажиллаж, 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн 2+4хөтөлбөр буюу Анагаахын Суурь Боловсролын Дамжаа /АСБД/-г нээснээр анагаахын суурь боловсролын хичээлийн хөтөлбөр бүх мэргэжлийн сургалтанд ижил болж, анагаахын суурь боловсрол эзэмшсэний дараа мэргэжлийн чиглэлээ сонгон суралцах сургалтын хэлбэрт шилжсэн байна. Энэхүү хөтөлбөрийн шинэчлэл нь анагаахын суурь хөтөлбөрөөс “Уламжлалт анагаах ухаан” сургалтын хөтөлбөрт элсэн суралцагчид бусад хөтөлбөрт элсэн суралцагчидтай адил агуулга, багтаамжтай хичээлийг судлан, МАУОУС-д элсэн суралцах боломжийг бий болгосон нь өмнөх магадлан итгэмжлэлийн үеийн сургалтын хөтөлбөрөөс давуу талтай гэж үзэж байна.

БСШУС-ын 2014 оны А/174 тоот тушаалын хүрээнд “Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөрийн зөвлөлийг АШУҮИС-ийн захирлын 2015.10.09-ний А/113 тоот тушаалын дагуу боловсролын асуудал эрхэлсэн тэргүүн дэд захирлаар ахлуулан, МАУОУС-ийн захирал тэргүүтэй тус сургуулийн 3 тэнхмийн эрхлэгчийн /дотор өвчин судлал, зүү төөнө засал, заслын тэнхим/бүрэлдэхүүнтэй нийт 7 хүнтэй байхаар зохион байгуулсан. Уг зөвлөл нь дотооддоо чанарыг хангах, баталгаажуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, чанар сайжруулах талаар болон хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хагас жил тутам тайлагнах үүргийн дагуу үр дүнтэй ажилласан байна.

“Уламжлалт анагаах ухаан” хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт үнэлгээг хийхдээ дараах бичиг баримтанд тулгуурлан үнэлдэг байна. Үүнд:

- АШУҮИС-ийн захирлын А/118 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагааг зохицуулах журмын 8-р заалтад тусгасан “багшийн ажлын хавтас” хэмээх багшийн боловсролын болон мэргэжлийн түвшинг илэрхийлэх баримтууд, сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа болоон бусад мэдээллүүдийг багтаасан бичиг баримт. Тухайн сургуулийн багш нар нь албан тушаалын зэрэглэлээсээ хамаарч, сургалт, эрдэм шинжилгээ, төсөл, илтгэл хэлэлцүүлэг, мэргэжлийн үйл ажиллагаа хэмээх үзүүлэлтээр тодорхой шалгууртай байдаг ба энэ шалгуурын дагуу багшийн ажлын хавтсыг багш бүр жил болгон бүрдүүлж, хяналт хийлгэн, ажлаа дүгнүүлдэг байна.
- Тухайн сургуулийн сургалтын бодлого зохицуулалтын албанаас боловсруулсан загвар бүхий “багшийн ажлын дэвтэр”-ийг жил бүр хэвлэн, хөтөлбөрт оролцож буй нийт багш нарт олгодог бөгөөд түүний хөтлөлтөөр хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ өгдөг байна.
- Багшийн ажлын дэвтэрт буй “багшийн хичээлд суусан тэмдэглэл”. Энэхүү тэмдэглэлд салбарын тэнхимийн эрхлэгч, профессорын багийн ахлагч нар тухайн хөтөлбөрийн багш нарын хичээлд сууж, сургалтын технологид хяналт үнэлгээ хийдэг байна.

Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангах удирдлага, зохион байгуулалтад хөтөлбөрийн оролцогч, сонирхогч талуудыг хамруулан оролцуулж, хяналтыг багшийн арга зүй, ур чадвар, сургалтын орчин, материаллаг бааз, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, мэргэжилтний ур чадвар гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр үнэлдэг байна.

“Уламжлалт анагаах ухаан” сургалтын хөтөлбөрт шинэчлэл хийх зорилгоор АШУҮИС-ийн захирлын зөвлөл, эрдэмтдийн зөвлөл, эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлдэг байна.

Тус хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг асуумжийн арга, баг бүлгээр ажиллах, семинар, үр дүнгийн гэрээгээр хянадаг нь хөтөлбөрийн чанар, үр дүнд сайн нөлөөг үзүүлж байна.

Зөвлөмж: Уламжлалт анагаах ухаан хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээг сайжруулах талаар санаачилгатай ажиллах

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

“Уламжлалт анагаах ухаан” D091701 бакалаврын сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх найман шалгуур, хорин ёс үзүүлэлтийн дагуу бичсэн өөрийн үнэлгээний тайлан зэрэг баримт бичигтэй танилцаж, эдгээрийг нотлох сургалтын үйл ажиллагаа, үйл ажиллагааг зохион байгуулж буй удирдлага, багш сурган хүмүүжүүлэгчид, ажилтан албан хаагчид, боловсролын үйлчилгээ авч буй суралцагчид, төгсөгчид, ажил олгогчидтой уулзав. Түүнчлэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа сургалтын орчин нөхцөл, сургалтын хэрэгсэл, хэрэглэгдэхүүн зэргийг бодит байдал дээр нь нүдээр үзэв. Мөн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мөрдөж буй эрх зүйн актууд, тухайн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр, төлөвлөгөө болон бусад нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн “Уламжлалт анагаах ухаан” сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэж байгаа тул нийт 8 шалгуур, 29 дэд үзүүлэлтээс шалгуурыг “бүрэн хангасан” дэд үзүүлэлт 26, “хэсэгчлэн хангасан” дэд үзүүлэлт 3 байгаа бөгөөд нийт 89.6 хувийн үзүүлэлттэй байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн “Уламжлалт анагаах ухаан” бакалаврын сургалтын хөтөлбөрийн багт өөрийн үнэлгээний тайланг магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт бүрээр бичиж боловсруулахдаа ахиц дэвшлээ илүү тодорхой, дүн шинжилгээтэй гүйцэд гаргаж, цаашид хөгжих хандлагаа илүү тод дүрслэн гаргаж байхыг хүсэж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Ц.Дэлгэрсайхан/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Д.Самбуудорж/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Б.Наранцэцэг/

**Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн МАУОУС-ийн
“Уламжлалт анагаах ухаан” сургалтын хөтөлбөр дээр ажиллах
шинжээчдийн ажлын хуваарь**

2017 оны 12-р сарын 14

Хугацаа	Үйл ажиллагаа	Өрөө	Хариуцах албан тушаалтан
2017 оны 12 сарын 14-ний Пүрэв гариг			
9.00-10.30	БМИҮЗ-өөс томилогдсон шинжээчдийн багийг танилцуулах	238	БМИҮЗ-ийн төлөөлөл
	Шинжээчийн багийн ахлагч магадлан итгэмжлэлийн үйл явцыг танилцуулах	238	Шинжээчийн багийн ахлагч
	МАУОУС-ийн товч танилцуулга	238	Захирал Д.Цэрэндагва
	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажил, өөрийн үнэлгээний тайлангийн танилцуулга	238	Өөрийн үнэлгээний багийн ахлагч Б.Цэрэнцоо
	Сургуулийн удирдлага, өөрийн үнэлгээний багийн гишүүдтэй уулзалт хийх	238	Шинжээчийн багийн ахлагч
10.30-11.30	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	238	Шинжээчид
11.30-13.00	- Номын сан - Уламжлалт анагаах ухааны эмнэлзүйн ур чадварын лаборатори - Оюутан солилцооны тайлан 505 - Багш хөгжлийн төв - Цахим сургалтын төв - Үнэлгээний төв - Монгол анагаах ухааны өв уламжлалыг хадгалах, хамгаалах, сурталчилах сургалтын үзмэрт танхим	Номын сан 404 505 Үзвэрт танхим	Шинжээчид Д.Цэрэндагва С.Оюунцэцэг
13.00-14.00	Үдийн хоол		Оюутны хоолны газар
14.00-14.30	Эмнэлзүйн сургалтын үйл ажиллагаатай танилцах - Их сургуулийн нэгдсэн эмнэлэг - Монгол анагаах ухааны клиникийн эмнэлэг - УАУТХ-ийн эмнэлэг	АШУҮИС ИСНЭ МАУКЭ УАУТХ	Шинжээчийн баг Д.Цэрэндагва С.Оюунцэцэг Б.Цэрэнцоо
14.30-15.30	- Монгол анагаах ухааны клиникийн эмнэлэг	МАУКЭ	Шинжээчийн баг Н.Оюунцэцэг
15.30-16.30	Ажил олгогчидтой хийх уулзалт	УАУТХ	Шинжээчийн баг С.Сээсрэгдорж Ажил олгогчийн төлөөлөл

16.30-17.30	Төгсөгчидтэй хийх уулзалт	УАУТХ	П.Молор-Эрдэнэ Төгсөгчдийн төлөөлөл
2017 оны 12 сарын 15-ны Баасан гариг			
9.00-10.30	Нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	238	Шинжээчид
10.30-11.45	Багш нартай уулзах уулзалт		Шинжээчид Багш нар
11.45-13.00	Оюутнуудтай уулзалт хийх - 3-6-р дамжааны оюутан - Гадаадын суралцагч - Оюутны нийгэмлэг, холбоодын ахлагч нар	АШУУИС 140	Шинжээчийн баг Багш нар
13.00-14.00	Үдийн хоол		Оюутны хоолны газар
14.00-16.00	Нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	238	Шинжээчид
16.00-17.00	Шинжээчид дүгнэлтээ танилцуулах	238	Шинжээчид

Хавсралт 2

Уулзалтанд оролцогчдын нэрс:

Ажил олгогчдын төлөөлөл

Дд	Овог	Нэр	Ажлын газар	Албан тушаал	Төгссөн он	Утас	Гарын үсэг
1	Адилбиш	Цолмон	БЗНЭ	СЗУАУТөвийн эрхлэгч	1995	99179684	
2	Ш	Батноров	УАУТХ	Их эмч	1999	99566741	
3	Д	Амарзаяа	УАУТХ	Их эмч	1998	99732617	
4	Жаргалсайхан	Бат-эрдэнэ	УАУТХ	ЭШ дэд ажилтан	2013	99069649	
5	Ганзориг	Одхүү	СБИЭ	Тасгийн эрхлэгч	2014	88643939	

Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог	Нэр	Ажлын газар	Албан тушаал	Төгссөн он	Утас
1	Шаравсамбуу	Мөнгөнтуяа	ТТАХ нэгдсэн эмнэлэг	УА-ны тасгийн эрхлэгч	1997	99276372
2	Ганхуяг	Намгар	ЗТЗ резидент		2014	88023586
3	Цогзол	Мөнхтуул	УАУТХ	ЭШТ ажилтан	2016	88094392
4	Цогбадрах	Бямба-Очир	УАУТХ	Их эмч	2014	99884242
5	Батдэлгэр	Нямжав	Эрдэм их сургууль	УАУ-ны багш	2014	88015586
6	Ганбаатар	Амгаланбаатар	Дорноговь УАУ ны РСТ төв	Их эмч	2014	99486622
7	Ганбат	Гүнжинлхам	ОХУ Улан Удэ	УАУ ЗТЗ их эмч	2009	99041688
8	Энхбат	Амармэнд	УАУТХ	Их эмч	2002	99052413

9	Энхболд	Жаргалхүү	УАУТХ	Их эмч	2013	93064646
10	Содням	Энхжаргал	УАУТХ	Их эмч	1998	96660708
11	Чимэд	Шинэбаяр	УАУТХ	Бариааны сувилагч	2004	99147054
12	Шагдар	Батноров	УАУТХ	Их эмч	1999	99166741
13	Ганхуяг	Лхамсүрэн	УАУТХ	Их эмч	2014	99789399
14	Жанцандорж	Мөнхбат	УАУТХ	Их эмч	2011	88053688
15	Бямбадалай	Нямсүрэн	УАУТХ	Их эмч	2014	98113545
16	Баасантогтох	Цэрэнтогтох	Ээлт Ой сувилал	Их эмч	2015	88009750
17	Доржсүрэн	Тогтох эрдэнэ	УАУТХ	Их эмч	1997	99037708
18	Гомбо	Энхбаясгалан	Баясгалантай дэлхий эмнэлэг	Их эмч	2010	99038252
19	Долгормаа	Байгалмаа	УВ-ББУ сум ЭМТ	эрхлэгч эмч	2014	99669831
20	Ганзориг	Ууганцэцэг	Дорнод СЗТ	Их эмч	2014	91100424
21	Эрдэнэ очир	Батзул	Хос шинэс сувилал	УА эмч	2013	89022227
22	Хашбат	Пүрэвжав	Ачлахуй ЭЭМТ	Их эмч	2015	89988282
23	Дамдин	Энхзаяа	УАУТХ	Их эмч	2002	99052413

Багшийн төлөөлөл

**2017-12-15
АШУУИС 238 тоот**

№	Овог нэр		Утасны дугаар
1	Ш.Болд	ДӨСудлалын тэнхим, профессор	99111418
2	Г.Мөнхзул	УАУЗаслын тэнхим, дадлагажигч багш	88186503
3	Н.Занди	УАУЗаслын тэнхим, дадлагажигч багш	99188136
4	Э.Уянга	Зүү төөнө заслын тэнхим, дадлагажигч багш	99951726
5	С.Солонго	Арга зүйч	99095254
6	Ч.Батнайрамдал	ДӨСудлалын тэнхим, ахлах багш	99717236
7	Д.Энхмаа	Зүү төөнө заслын тэнхим, дадлагажигч багш	99798974
8	Д.Чулуунчимэг	ДӨСудлалын тэнхим, ахлах багш	99722613
9	П.Молор-Эрдэнэ	ДӨСудлалын тэнхимийн эрхлэгч	99521465
10	Д.Цэнд-Аюуш	МАУСудлалын тэнхим	99277344

Оюутны төлөөлөл

№	Овог	Нэр	Анги	Утасны дугаар
1	Сауле	Аюум	601 хэсэг	99423380
2	Батбаатар	Пүрэв	507 хэсэг	99537219
3	Сүхбаатар	Нямцэцэг	506 хэсэг	95199414
4	Пүрэвдорж	Эрдэнэбулган	506 хэсэг	96244446
5	Дүгэрсүрэн	Хоролсүрэн	301 хэсэг	98918911
6	Лхамжав	Баярцогт	Зүү-301 хэсэг	85821030
7	Мөнхбат	Энхчимэг	301 хэсэг	89128021
8	Сумьяа	Айзам	406 хэсэг	99653396
9	Баясгалан	Бямбарагчаа	406 хэсэг	88264149
10	Мөнхбаяр	Цагаандарь	406 хэсэг	99316020